

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ХҮЛЭЭН АВАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ
УДИРДАМЖ, ТАЙЛАН
/ 2005 ОН /**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3

“МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ОЛЖ АВАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улс дахь мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлоход чиглэгдэж байв.

Судалгааны ажлыг дор дурдсан гурван зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох;
2. Сэтгүүлчийн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох;
3. Иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн эрх зүйн орчныг судлах.

Эцэст нь судалгааны тайлан бичиж санал, зөвлөмж бэлтгэсэн болно.

Судалгааны зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг багцлан үзүүлбэл,

Нэг. Иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох зорилтын хүрээнд дор дурдсан судалгааны ажлыг хийв. Үүнд:

1.1. Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлын төвшинг тодорхойлох;

1.2. Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийн төлөв байдлыг тодорхойлох

Хоёр. Сэтгүүлчийн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлах зорилтын хүрээнд дор дурдсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

2.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний нэр, нэр төр, алдар хүндийг гутаасан хэрэг маргааныг Нийслэлийн дүүргийн шүүхээр хэрхэн шийдвэрлэсэн талаар судлах;

2.2. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн баталгаа.

Гурав. Иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн эрх зүйн орчныг судлах зорилтын хүрээнд дор дурдсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

3.1.Гадаадын зарим улс орны мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн талаархи судалгаа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГ.ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ОЛЖ АВАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1.Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлын төвшин

Ардчилал нь төр засгийн шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэний ухамсартай, идэвхтэй оролцоо нь дээр тогтдог. Монгол улсын иргэн бүрт төр засгийн үйл ажиллагааг нээлттэй байдлаар харах бололцоог бүрдүүлэх хэрэгтэй юм. Үүнийг ил тод, нээлттэй байдал гэж томъёолдог. Энэ нь төрийн үйл ажиллагаа иргэний хяналтгүй, хаалттай байх, авилга үүсэх, эдийн засгийн хувьд үрэлгэн байх нөхцлийг арилгахад чухал үүрэгтэй. Засаг төрийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх үндсэн зарчим, түүний үзэл санаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, мөн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан Монгол Улсын иргэний мэдээлэл хайх, хүлээн авах үндсэн эрх, УИХ-ын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан УИХ-ын үйл ажиллагааны үндсэн зарчим, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан төрийн албанд баримтлах ил тод байх зарчим, Шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмаар тунхаглагдан мөрдөгдсөөр ирсэн билээ.

“Глоб интернейшнл” ТББ, Хууль зүй, Дотоод хэргийн Яам хамтран 2003 онд **“Төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал ба иргэдийн мэдээлэл олж авах эрх”** сэдэвт судалгааг хийсэн юм. Бид “Глоб интернэйшнл” ТББ-ын зөвшөөрлөөр энэхүү судалгааны анхдагч эх сурвалжид дахин боловсруулалт хийж Монгол Улсын олон улсын гэрээ, олон байгууллагаас гаргасан санал, зөвлөмжийг үндэслэн төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, иргэний мэдээлэл хүртэх эрхийн төлөв байдлыг судлан үнэлэлт, дүгнэлт өгөх зорилтыг тавьсан юм.

Судалгаанд УИХ-аас байгуулагддаг байгууллага 3, төрийн захиргааны төв байгууллага 9, шүүх эрх мэдлийн болон бусад байгууллагаас 11, Засгийн газрын тохируулагч агентлаг 7, хэрэгжүүлэгч агентлаг 17, нийт 47 байгууллага хамрагдсан юм. Мөн судалгааны хүрээнд төрийн байгууллагаас иргэд мэдээлэл олж авах эрхээ хэр зэрэг эдэлж байгааг тандах зорилгоор иргэдийн дунд **“Олон нийтийн мэдэх эрх”** сэдэвт судалгааг тусгайлан явуулсан юм. Энэ судалгааг

нийслэлийн хэмжээнд явуулсан бөгөөд янз бүрийн мэргэжил, боловсролтой 18-аас дээш насны нийт 100 иргэний дунд явуулсан болно.

Монгол улсад төрийн байгууллага нь олон нийтэд мэдээлэл түгээх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий газар, хэлтэс, албыг байгуулан ажиллаж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 47 байгууллагын 36 байгууллага нь (хавсралт-1) дээр дурдсан газар, хэлтэс, алба, хэвлэлийн төлөөлөгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Эдгээр газар, хэлтэс, алба нь дор дурдсан чиг үүрэг буюу үйл ажиллагаа, үйлчилгээг явуулдаг байна. Тухайлбал,

Хүснэгт-1

№	Чиг үүрэг	Төрийн байгууллага /тоо/
1.	Байгууллагын үйл ажиллагаа, ажлын үр дүнг олон нийтэд мэдээлэх /мэдээлэл түгээх/	29
2.	Иргэдэд мэдээлэл өгөх үйлчилгээ	23
3.	Тайлан мэдээ, баримтыг нэгтгэн дотоод, бусад байгууллагын хэрэгцээнд тараах	21
4.	Мэдээллийг төрийн, төрийн бус болон хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх үйлчилгээ үзүүлэх	21
5.	Статистик тоо, баримтыг харьцуулан дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулах	17
6.	Байгууллагын удирдлагын ажлын талаар мэдээлэх	15

Дүгнэн үзвэл, төрийн байгууллагууд нь үйл ажиллагаагаа дээд зэргээр ил тод байлгах, иргэний мэдээлэл хайх, олж авах эрхийг хангах чиг үүргээс илүүтэйгээр байгууллагын тайлан мэдээ, баримтыг удирдах байгууллага, албан тушаалтан болон төрийн эрх бүхий зарим байгууллагад ажил тайлагнах зорилгоор цөөн тоогоор хүргүүлэх, статистик тоо, баримтад дүн шинжилгээ хийж ажлын хэрэгцээнд тараах, хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээллийн зэрэг байгууллагын хүсэлтийг харгалзан зарим мэдээллийг удирдлагын зөвшөөрлөөр өгөх зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа нь харагдана.

Хэрэгжүүлбэл зохих чиг үүргийг гүйцэт бус, заримыг нь түлхүү хэрэгжүүлдэгээс төрийн байгууллагын хурал, уулзалт, семинар зохион байгуулсан болон удирдлагын үйл ажиллагааны тухай, байгууллагын сурталчилгааны тухай мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр давамгайлах хандлага үзэгдэж байна.

№	Төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа мэдээллийн төрөл, агуулга, хүрээ	Төрийн байгууллага /тоо/
1.	Уулзалт, хурал, семинар зохион байгуулсан тухай мэдээлэл	33
2.	Байгууллагын сурталчилгаа	29
3.	Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал	26
4.	Байгууллагын үйл ажиллагаа болон үр дүнгийн тухай тогтмол гаргадаг мэдээлэл	22
5.	Байгууллагын удирдлагын үйл ажиллагааны тухай мэдээлэл	16
6.	Иргэд, олон нийтээс танай байгууллагад шууд хандан мэдээлэл хэрхэн хүсэх тухай	11
7.	Байгууллагын тухай тогтмол мэдээлэл, түүний дотор зорилго, зардал, тайлан тооцоо, орон тоо, бүтэц, үр дүнгийн тухай мэдээлэл	8
8.	Байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл, зүйл, хэлбэр	4

Судалгаанд оролцогч төрийн байгууллагууд олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал (26 байгууллага), байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн тухай тогтмол мэдээлэл (22 байгууллага) түгээдэг гэж хариулсан ч бодит байдал дээр ийм мэдээлэл туйлын хомс байдаг билээ.

Энэ байдлыг зарим нэг талаар гэрчлэх баримтыг дурдвал, Хууль зүй, дотоод хэргийн яам болон сайдын эрхлэх хүрээний агентлагуудаас 2001 онд мэдээлэл, олон нийттэй харилцах талаар дор дурдсан арга хэмжээг зохион байгуулсан тухай тайлан гаргажээ. Тухайлбал, яамны үйл ажиллагааны сурталчилгаа, мэдээллийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний асуудал, харьяа агентлагийн үйл ажиллагаатай холбогдох 337 гаруй мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 1145 (давхардсан тоогоор) удаа мэдээлэх ажлыг зохион байгуулж, яам 9 удаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 2, шүүхийн ерөнхий зөвлөл 1 удаа хэвлэлийн бага хурал хийжээ. Яамны мэдээллийн тохимол “Мэдээлэл” сэтгүүлийг сар тутам тус бүр 30-40 хуудсаар гаргаж, 200 гаруй байгууллагад тараасан байна. Түүнчлэн “Зууны мэдээ” сонинтой хоёр жилийн хугацаатай гэрээ байгуулан үнэ төлбөргүйгээр яамны “Хууль, эрх зүй” нүүрийг сар тутам гаргаж, уг нүүрэнд хууль тогтоомжийн хялбаршуулсан тайлбар, өгүүлэл болон мэргэжлийн хуульчдын дунд хэлэлцүүлэг болгох зорилгоор хууль, хуулийн төслийн талаарх материал, яамны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, материалыг нийтэлжээ. Сайд болон яамны удирдлагуудыг Монголын Үндэсний телевизийн эвлүүлэггүй яриа шууд нэвтрүүлэгт 5 удаа, МН-25 телевизийн 1x1

8

шууд нэвтрүүлэгт 2 удаа, UBS телевизийн “Нүүр тулсан яриа” нэвтрүүлэгт 1 удаа, MYTB, Ийгль, МН-25, UBS телевизийн мэдээллийн нэвтрүүлгүүдэд тус бүр 37 удаа оролцсон байна. Монголын радиогийн шууд нэвтрүүлэгт 5 удаа, Монголын Үндэсний радио болон Улаанбаатар радиогийн мэдээллийн хөтөлбөрөөр нийт 35 удаа, Үнэн, Өдрийн сонин, Зууны мэдээ, Монголын Мэдээ зэрэг сонинуудад тус бүр 31 удаа ярилцлага өгчээ.

ЦЕГ. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст орон тооны бус хэвлэлийн төлөөлөгч нарыг томилон ажиллуулж, үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэх ажлыг цагдаагийн газар, хэлтсийн дарга нар шууд хариуцан, хяналт тавьж ажиллаж, ЦЕГ-ын хүрээнд нэгтгэн зохицуулах асуудлыг ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн алба хариуцан ажиллаж байжээ. ЦЕГ-с 2001 онд 3 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, өдөр тутмын томоохон сонин хэвлэлүүдтэй хамтран “Цагдаагийн мэдээлэл” булан тогтмол ажиллуулж, Монголын Үндэсний телевиз, UBS телевизээр 14 хоног тутам “Цагдаагийн мэдээлэл”, “Сэрэмжлүүлэг” нэвтрүүлгийг тухай бүр зохион байгуулжээ.

Хилийн цэргийн удирдах газар. ХЦУГ-ын даргын А/11 тоот тушаал гаргаж “Хилийн цэргийг удирдах газрын орон тооны бус хэвлэл мэдээллийн албыг байгуулж, ажиллах журмыг батлан мөрдүүлж байгаа бөгөөд 2001 онд 1 удаа хэвлэлийн бага хурал хийж, Монголын Радиогийн “Сургалт танин мэдэхүй”-н алба, Зууны мэдээ, Хоршооллын мэдээ, Соёмбо сонинуудтай хамтран байнгын гэрээтэй ажиллаж байна. Эл хугацаанд 16 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 304 мэдээ, мэдээллийг түгээсэн байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар. ШШБЕГ 2001 онд 2 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 76 мэдээ, мэдээллийг түгээжээ. “Өдрийн сонин”, Монголын радиогийн улс төр, хууль зүйн албатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. ШШБЕГ-ын харьяа хорих байгууллагуудаас Монгол телевиз, Монголын радио, МН-25 телевизид нэвтрүүлэг бэлтгэн явуулж, Зууны мэдээ, Үнэн, Монголын Мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр сонинуудад байгууллагынхаа сурталчилгааг нийтлүүлжээ.

Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвөөс 2001 онд 1 удаа хэвлэлийн бага хурал хийж, ММ агентлаг, МОНЦАМЭ, Монголын мэдээ, Зууны мэдээ сонинтой хамтран ажиллаж, нийт 71 мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн байна.

Гал түймэртэй тэмцэх газар. Тус газар нь байгууллага дээрээ мэдээлэл сурталчилгаа хариуцсан ажлын байр бий болгож, хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх мэдээллийг зөвхөн хэвлэлийн төлөөлөгчөөр дамжуулан түгээх журамд шилжин ажиллаж байна.

2001 онд 2 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 465 мэдээ, мэдээллийг түгээжээ. Мөн тус газраас “Харанга” сонинг эрхлэн гаргаж байгаа бөгөөд байгууллага, аж ахуй нэгжид галын аюулаас урьдчилан сэргийлэх яриа, таниулга 135 удаа хийж, Зууны мэдээ, Өнөөдөр, Улаанбаатар сонин, Монголын Радио, телевизтэй хамтран ажиллаж байна гэжээ.

Төрийн байгууллагын хэвлэн нийтэлбэл зохих мэдээллийн төрөл зүйлийг хуульчилах нь зүйтэй. Өнөөдөр ямар мэдээллийг хэвлэн нийтлэх нь тухайн байгууллагын үзэмжийн хэрэг юм. Тийм учраас зөвхөн сурталчилгааны зорилготой, үйл ажиллагаатай тухай мэдээлэл голлон түгээгдэж байна. 19 дүгээр зүйл байгууллагаас боловсруулсан Олон нийтийн мэдэх эрх-Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмын (олон улсын стандартын цуврал) 2 дахь зарчим нь “Хэвлэн нийтлэх үүрэг” юм.

Уг зарчмаар төрийн байгууллагууд нь чухал мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг хүлээх ёстой болдог. Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулна гэдэгт төрийн байгууллагууд зөвхөн мэдээлэл олж авах хүсэлтэд хариу өгөөд зогсохгүй мөн нөөц бололцоо, хүчин чадлынхаа хэмжээгээр олон нийтийн сонирхлыг ихээр татсан онцгой мэдээллийг хэвлэн нийтэлж, тарааж байх үүрэг хүлээх явдал багтдаг. Чухам ямар мэдээллийг хэвлэн нийтлэж, тарааж байх нь тухайн байгууллагаас шалтгаална. Гэхдээ хуулиар хэвлэн нийтлэх ерөнхий үүрэг ба хэвлэгдэж олон нийтэд хүрч байх ёстой мэдээллийн төрлийг тогтоож өгнө. Төрийн байгууллагууд нь наад зах нь дор дурдсан мэдээллийг хэвлэн нийтлэх үүргийг хүлээнэ. Үүнд:

1.Тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл, түүний дотор зардал, зорилго, тайлан тооцоо, стандарт, үр дүн гэх мэт. ялангуяа тухайн байгууллагын олон нийтэд үзүүлдэг шууд үйлчилгээ;

2.Олон нийтээс тухайн төрийн байгууллагад шууд хандан мэдээлэл хэрхэн хүсэх буюу гомдол гаргах зэрэг тухай;

3.Байгууллагын томоохон хэмжээний бодлого, хуулийн төсөлд олон нийтийн зүгээс санал бодлоо оруулахад дагах журам, аргачлал;

4.Тухайн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийн төрөл зүйл, хэлбэр;

5.Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал гэх мэт.

Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болох Монголын Үндэсний Телевиз нь эрх барьж буй Засгийн газар болон УИХ-ын үйл ажиллагаа, бодлого, шийдвэрийн талаар мэдээллийг ихэвчлэн эерэг болон төвийг сахисан байр сууринаас, Улаанбаатар телевиз нийт мэдээнийхээ 48 хувьд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, нийслэлийн хороо, дүүргүүдийн үйл ажиллагааны талаар мэдээлсэн бөгөөд эдгээрийг 100 хувь эерэг байр суурьнаас цацжээ.¹ Судалгааны дүнгээс харахад 20-иос дээш төрийн байгууллагатай харьцдаг 8 хэвлэл мэдээллийн байгууллагын 4 нь төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 4 нь улс төрийн хүчний сонин гэх нэр зүүдэг өдөр тутмын сонин байгаа юм. (Хүснэгт-3) Төрийн байгууллагууд төрийн мэдлийн болон аль улс төрийн хүчний гэх өдөр тутмын сонин, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй илүү хамтран ажилладаг байна. Түүнчлэн төрийн байгууллагууд нь иргэдэд мэдээлэл өгөхөөс илүү байгууллагын зар сурталчилгаанд илүү мөнгө зардаг нь дараахь тоо, баримтаар батлагдаж байна.

Сүүлийн жилүүдэд төсвийн болон төрийн өмчит байгууллагууд төрийн өмч хөрөнгийг ашиглан өөрийн байгууллагын тухай ач холбогдол багатай сурталчилгааг сонин хэвлэлээр их явуулах болов. Монгол улсын Төрийн хянан шалгах хорооноос 2001 онд хийсэн судалгаанд “өнгөрсөн хоёр жилд зөвхөн “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонинд 80 шахам төсөвт болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага танилцуулга сурталчилгаа, фото зураг нийтлүүлж, наад зах нь 20 гаруй сая төгрөг зарцуулсан байна. Бусад хэвлэл болон радио, телевизээр явуулж байгаа сурталчилгааг тооцвол үүнээс хавьгүй их тоо гарах нь ойлгомжтой. Бидний хийсэн судалгаагаар дээрх дүгнэлт батлагдаж байгаа бөгөөд ялангуяа сүүлийн жилүүдэд эрх баригч намын хэвлэл “Үнэн” сонинд төсвийн болон төрийн өмчит байгууллагууд өөрийн сурталчилгааг гаргах нь эрс ихэссэн байна. “Үнэн” сонинд нэг сард дунджаар төсвийн болон төрийн өмчит байгууллагууд 3.9 сая төгрөгний сурталчилгааг гаргадаг байна. Зөвхөн

¹ Хэвлэлийн хүрээлэн, “Телевизийн мэдээллийн хөтөлбөрийг задлан шинжлэх судалгааны тайлан, УБ., 2003 он

2001 оны 11 сарын 13-аас 2002 оны 3 сарын 7-ныг хүртэл хугацаанд тус сонинд Санхүү, Эдийн засгийн яам, Төв аймаг, Дархан-уул аймгийн Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар, СХД-ийн татварын хэлтэс, Зэвсэгт хүчний клиникийн эмнэлэг зэрэг төсөвт болон төрийн өмчит (давхардсан тоогоор) 101 байгууллага нийтдээ 16 сая төгрөгний сурталчилгаа гаргажээ. Зарим байгууллага нилээд олон удаа өөрсдийгөө сурталчилжээ. Тухайлбал, дээрх хугацаанд “Үнэн” сонинд Нефть импорт концерн (НИК) 13 удаа бүгд 2.6 сая төгрөгний, МИАТ компани 12 удаа 1.2 сая төгрөгний, яамдууд 8 удаа бүгд 1.3 сая төгрөгний, аймгууд 6 удаа 1.2 сая төгрөгний сурталчилгаа гаргасан байна.²

Хүснэгт-3

№	Төрийн байгууллагуудаас байнгын харилцаа холбоотой ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагууд	Төрийн байгууллага /тоо/
1.	“Зууны мэдээ” сонин	32
2.	Монголын радио	31
3.	МҮТВ	30
4.	“Өнөөдөр” сонин	28
5.	“Үнэн” сонин	25
6.	“Өдрийн сонин”	23
7.	Улаанбаата телевиз	22
8.	МОНЦАМЭ	20
9.	МН-25 ТВ	15
10.	“Монголын мэдээ” сонин	13
11.	PM радио	7
12.	“Сэрүүлэг” сонин	5
13.	“Хүмүүс” сонин	5
14.	Сэтгүүлчдтэй гэрээ байгуулж	3
15.	“Улаанбаатар таймс” сонин	2
16.	UB Post	1
17.	Mongolia this week	1

Судалгаанд оролцсон иргэд төрийн байгууллагаас дор дурдсан мэдээллийг мэдэх хүсэлтэй гэж хариулжээ. Үүнд:

УИХ МН
СУДАЛГААНЫ САН
Хүснэгт-4

№	Мэдэхийг хүсч буй мэдээлэл	Саналын тоо /иргэн/
1.	Байгууллагын ажлын үр дүнгийн тухай	32
2.	Байгууллагын орон тоо, бүтэц, зохион байгуулалт	23
3.	Удирдлагын үйл ажиллагаа, цалин, хангамж	16
4.	Тушаал, шийдвэр, гэрээ, ирсэн, явуулсан албан бичиг хэрэг зэрэг	14

² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, ТХШХ-ны шалгалт, судалгааны материал, 2001 он

	баримт бичиг	
5.	Байгууллагын төсөв, зардал, тайлан тооцоо	20
6.	Байгууллагын нууц, төрийн нууц	3
7.	Байгууллагын стратеги төлөвлөгөө	19
8.	Дотоод баримт бичгүүд	2
9.	Байгууллагын сурталчилгаа	17
10.	Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал	62
11.	Байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл, зүйл, хэлбэр	14
12.	Гадаад томилолтын зардал	5
13.	Хүлээн авалт, дайллага, цайллагын төсөв, зардал	7
14.	Албан хаагчдын анкет, хувийн хэрэг	6
15.	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх өөрт хэрэгцээтэй мэдээллийг	40
16.	Олон нийтэд үйлчилгээтэй холбоотой мэдээлэл	1
17.	Хуулиар нууцалснаас бусад бүх мэдээллийг	1

Цөөн тооны иргэд байгууллагын дотоод бичиг баримт, төрийн болон байгууллагын нууц, албан хаагчдын анкет, хувийн хэргийг “мэдэх эрх”-тэй мэдээлэл гэж үзсэн нь мэдээллийн ил тод, нээлттэй байх хүрээ, хязгаарын талаарх ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалсан гэж үзэж болох юм.

Харин дийлэнх иргэд олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал, байгууллагын ажлын үр дүн, орон тоо, бүтэц, зохион байгуулалт, стратеги төлөвлөгөө, төсөв, зардал, тайлан тооцоог “мэдэх эрх”-тэй мэдээлэл гэж үзсэн нь төлөөллийн зарчмаар байгуулагдсан ардчилсан төрийн үед байх ёстой, зүй ёсны асуудлын нэг болно.

2004 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн 4 дүүргийн ЗДТГ-т ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Хүснэгт-5

Д/д	Дүүрэг	Өргөдөл гомдлын тоо	Ирүүлсэн хэлбэр		Шийдвэрлэлт					
			амаар	Бичгээр	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж хариу авсан	Хуулинд заасан хугацаанд шийдвэрлэсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	огт шийдээгүй
1.	БЗД	4878	1168	3710	4519	48	4567	-	311	-
2.	ЧД	736	433	303	628	73	701	-	35	-
3.	ХУД	4509	1182	3327	4509	956	4509	-	-	-
4.	СБД	4324	14	4310	3593	11	3625	21	699	-
	ДҮН	14447	2797	11650	13249	1088	13402	21	1045	-

Хүснэгт-6

Д/д	Өргөдөл гомдлын агуулга	Дүүрэг			
		ЧД	СБД	ХУД	БЗД
1.	Орон гэр, орон сууц хүссэн	110	117	491	574
2.	Газар хүссэн, газрын тухай асуудлаар	62	1550	2101	4020
3.	Мөнгөн болон материаллаг тусламж хүссэн	62	631	213	83
4.	Бусад асуудлаар	502	2026	1704	197

Иргэдийн дунд төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх амьдрал дээр хэр зэрэг хэрэгжиж байгаа талаар явуулсан судалгаагаар судалгаанд оролцогсдын:

- 4 хувь нь "хангалттай";
- 28 хувь нь "дунд зэрэг";
- 68 хувь нь "тааруу", "огт хэрэгжихгүй байгаа" гэж үзжээ. Гэхдээ энэ тоо баримт нь судлагдаж байгаа зүйлийг хангалттай төвшинд илэрхийлэх тоо, хувь хэмжээ биш ч гэсэн, судалгаанд хамрагдсан ихэнх иргэд төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх хэрэгждэггүй гэж үзсэн нь анхаарал татаж байгаа юм.

Мөн судалгаанд оролцогсдын 69 хувь нь төрийн ямар нэг байгууллагаас мэдээлэл олж авах хүсэлтийг гаргаж байгаагүй гэж хариулсан бөгөөд тэдгээр иргэд энэ шалтгаанаа:

- төрийн байгууллага, албан тушаалтан мэдээлэл өгдөггүй;
- танил тал байхгүй;
- хүнд сурталтай гэж үздэгээс ханддаггүй гэж тайлбарлажээ.

Хүсэлт тавьж хандаж байсан гэх 31 хүний 85 удаагийн хүсэлт гаргаж хандсан байгууллагын харьцааг /давхардсан тоогоор/ үзвэл:

- Шүүх, цагдаагийн байгууллага-19
- Яам- 29

- ИТХ, Тамгын газар- 8
- Засгийн газар, ЗДТГ, агентлаг- 25
- Прокурорын байгууллага- 3
- ХЭҮК- 2
- Төрийн өмчийн байгууллага- 2

"Хүссэн мэдээллээ төрийн байгууллагаас авч чадсан уу? " гэсэн асуултад нийт судалгаанд оролцсон хүний 75 нь ямар нэг байдлаар хариулсан бөгөөд чадсан гэж тэдний дөнгөж 9 хүн нь, зарим үед гэж 5 хүн нь хариулсан бол үлдсэн 61 хүн нь авч чадаагүй гэжээ. Авч чадаагүй үндэслэлээ тэд тайлбарлахдаа:

Хүснэгт-7

	Татгалзсан үндэслэл	Иргэн /тоо/
1.	Удирдлага нь зөвшөөрөөгүй	10
2.	Төрийн нууц гэж хэлсэн	5
3.	Байгууллагын нууц гэж хэлсэн	5
4.	Мэдээлэл байхгүй гэсэн	12
5.	Албан хэргийн бичиг баримтыг жирийн иргэнд өгөхгүй гэсэн	11
6.	Мэдээлэл хариуцсан албан хаагч ямар ч шалтгаангүйгээр мэдээлэл өгөхөөс татгалзсан	13
7.	Мэдээллийг ашиглах зорилгоо хэлсэн чинь өгөөгүй	7
8.	Зав байхгүй гэдэг үндэслэлээр	1
9.	Дутуу дулимаг хариулт өгсөн	1
10.	Үнэ төлбөртэй байсан	1


Монгол Улсад өнөөдөр шүүх эрх мэдлийн шинэтгэл эрчимтэй явагдаж байна. Ардчиллын үзэл санаа болох ил тод, нээлттэй байдал нь шүүх эрх мэдэлд ч бас хамаатай юм. Монгол Улсын шүүх ил тод, нээлттэй байдлыг чухалчлан үздэг бөгөөд өнгөрсөн хугацаанд, шүүхүүд дээр мэдээллийн төв байгуулагдан, УДШ-ийн Ерөнхий шүүгчийн захирамжаар УДШ-ийн хэвлэл мэдээллийн алба, түүний ажиллах журам, УДШ-ийн тогтоолыг нийтэд ил тод байлгах, танилцах боломжоор хангах зорилгоор "Мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах, ашиглах журам"-ыг батлан, 1970-аад оны дунд үеэс эрхлэн гаргах болсон "Дээд шүүхийн мэдээлэл" сэтгүүлд УДШ-ийн зарим шийдвэрийг хэвлэн, 1995 оноос эхлэн онол, практикийн "Монголын төр, эрх зүй" сэтгүүл эрхлэн гаргаж, 2002, 2003 онд шүүхийн үйл ажиллагаа, түүний ажлын дүн мэдээг "Монгол Улсын шүүхийн жилийн тайлан" нэртэйгээр анх удаа олон нийтэд

нээлттэйгээр хэвлэн гаргасан зэрэг дэвшилттэй зүйл цөөнгүй бий. Гэвч ил тод, нээлттэй байдал үүгээр хязгаарлагдахгүй, цаашид хийх зүйл багагүй байна. Шүүхийн шийдвэр олон нийтэд ил тод байх нь орчин үеийн төр, эрх зүйн хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцүүлэн шүүхийг шинэчлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

“Зохистой бөгөөд үндэслэлтэй дээд шатны шүүхийн шийдвэрийг интернэтээс авч үзэж танилцах боломжтой байх ёстой. Эдгээр шийдвэрийн товчоо нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээгдэх ёстой. Ингэснээр маргаан өрнөж зарим эрдэмтэд шийдвэрийг бүхэлд нь сайшааж эсвэл шүүмжилж болох юм...бусад зүйлийн зэрэгцээ шийдвэр гаргасан үндэслэлийг нууцалсан тохиолдолд шүүхийн авилгал үүсч болзошгүй, эсвэл авилгал авч гаргасан шийдвэр нь мэдлэггүй шийдвэр гаргасан мэт харагдаж болзошгүй. Шүүгчийг үндэсний аюулгүй байдал, ардчиллын, хөгжлийн болон хүний эрхийн бодлогыг хэрэгжүүлэхгүй байна гэж зарчмын хувьд бүх нийтээрээ шүүмжлэх нь шүүгчийн бие даасан байдалд аюул занал учруулахгүй...”³

“Шүүхийн шийдвэр болон үндэслэлийг хууль зүйн мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлэх нь чухал ач холбогдолтой. Туршлагатай хуульчид, эрдэмтэд уг шийдвэрүүдийг онолын үүднээс тайлбарлаж, өөрийн санаа бодлоо хэлэх нь зөв юм. Шинжлэх ухааны ийм дискусс нь шүүхийн практикт ч сайнаар нөлөөлөх ба хууль зүйн тайлбарын чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.”⁴

Шүүхийн прецедентийг эрх зүйн эх сурвалж гэж үздэг нийтлэг эрх зүй тогтолцоотой улс орнуудаас зарчмын хувьд томоохон ялгаа бүхий “шүүхийн практик” гэсэн ойлголт иргэний эрх зүйн тогтолцоотой улс орнуудад бас бодитой байдаг. Тухайлбал “...Шүүгч шүүхийн прецедентээс үл хамааран чөлөөтэй шийдвэр гаргадаг байсан бол шүүхийн прецедентийг чухалчилж үзэх хэрэгцээ байхгүй байсан. Гэвч бодит байдал дээр шүүгчид шүүхийн прецедентийг чухалчилдаг бөгөөд шүүхийн системд шүүхийн прецедент нь тодорхой байр суурь эзэлж байдаг. Шүүгчид шүүхийн прецедентийг чухалчилдаг хамгийн гол шалтгаан нь 3 шатны шүүхийн системд оршино. Гурван шатны шүүхийн тогтолцоонд анхан шатны шүүхийн шийдвэр давж заалдах шатны шүүхэд хянагдах бөгөөд давж заалдах шатны шүүхийн шийдвэр



³АНУ-д хуулийг хэрхэн тайлбарладаг тухай:Монголчуудад тэр нь тохирох уу?, илтгэл, АНУ-ын Валпарайсогийн Их Сургуулийн багш, доктор, профессор Пол Х.Бритцке, 2001 оны 06 дугаар сарын 26-27-нд УДШ, Ханнс Зайделийн Сан хамтран зохион байгуулсан “Шүүх эрх мэдэл-Шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурлын баримт материал, 76 дахь тал, УБ.
⁴ Ард түмний тусгаар тогтнолын асуудал ба ардчилсан хууль ёсны гинжин холбоо, лекц, доктор Юрген Харбих, “Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” /Шүүгчид зориулсан гарын авлага/ Ханнс Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” Академи, УБ, 2004 он.

Улсын Дээд Шүүхэд хянагдана. Жишээлбэл, давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрээс ондоо шийдвэр гаргавал анхан шатны шүүхийн шийдвэр нь алдаатай байсан гэж дүгнэгдэнэ.

Түүнчлэн шүүхийн системд анхан шатны шүүх нь адил хэргийн талаар давж заалдах шатны шүүхийн шийдвэрээс зөрүүтэй шийдвэр дахин гаргаж чадахгүй болно. Тиймээс анхан шатны шүүх нь алдаатай шийдвэр гаргахыг хүсэхгүйн үүднээс давж заалдах шатны болон хянах шатны шүүхийн прецедентийг практик дээр удирдлага болгон шийдвэр гаргадаг болно.”⁵

Иймд ил тод, нээлттэй байдлын хүрээнд шүүхийн шийдвэрийг эмхтгэн гаргах нь шүүхийн шийдвэр нь өөрөө онол, практик судлалын эргэлтэд орж, шүүгч, хуульч, судлаач, эрдэмтэд, багш, оюутны гарын авлага, шүүхийн практик танин мэдэх, судлах сурах бичиг болох ач холбогдолтой юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁵“Япон Улс дахь шүүхийн прецедентийн эмхтгэл” илтгэл, Масанори Танабэ, ЖАЙКА-гийн эрх зүйн шинэчлэл төслийн мэргэжилтэн, “Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, ХЗҮТ, Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл, УБ., 2004 он, 36 дахь тал.

1.2. Иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн төлөв байдал

Иргэн бүр мэдээллийг чөлөөтэй эрж хайх, олж авах, түгээх эрхтэй. Гэвч энэхүү эрх бодитойгоор хэрэгжихэд төрийн захиргааны байгууллагын хүнд суртал (энэ нь мэдээлэл олж авах хүсэлт гаргасан иргэнд хамгийн их тохиолддог саад), хууль үл дээдлэх явдал, хуулийг өөрийнхөөрөө буруу тайлбарлаж хэрэглэх, даргаасаа зөвшөөрөл авдаг зэрэг нэгэнт тогтоод буй захиргааны байгууллагын буруу практик саад болж байна. Тухайлбал,

1. Төрийн байгууллагууд өөрийн мэдэлд байгаа мэдээлэл, баримт бичгийг “албаны баримт, албаны баримт бичгийг энгийн иргэнд хамаагүй өгч болохгүй” гэсэн хуучны арга барил, үзэл сэтгэлгээнээс салаагүй байна. Энэ нь төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалснаас бусад мэдээлэл, баримт бичигт ийм хандлагаар хандаж байна гэсэн үг.

Судалгаанд оролцсон төрийн байгууллагууд “Монгол улсын иргэд төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, олж авах эрхтэй” гэснийг бүгд дэмжсэн байдаг. Харин “Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хориглосноос бусад мэдээллийг танай байгууллагаас чөлөөтэй олж авах боломж хүн бүрт бий юу” гэсэн асуултад “тийм” гэж 39 байгууллага, 6 байгууллага “үгүй” гэж хариулсан нь эргэлзээ төрүүлэхээр байна. Юунд эргэлзээ төрж байна вэ гэхэд, “үгүй” гэж хариулт өгсөн 6 байгууллага төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуульд зааснаас бусад мэдээлэл нээлттэй, нууц биш байна гэдэг Үндсэн хуульд заасан үзэл санааг ойлгож байна уу, үгүй юу гэдэгт, мөн хуулиар хамгаалснаас бусад мэдээллийг манай байгууллагаас чөлөөтэй авах боломжтой гэж 39 байгууллага хариулсан ч энэ нь бодит ажил болж чаддаггүй билээ. Энэ нь төрийн байгууллагуудад өөрт байгаа мэдээлэл, баримт бичгээ нууцлах хандлагатай гэдгийг харуулж буй юм.

Энэ талаар “19 дүгээр зүйл” байгууллагаас боловсруулсан Олон нийтийн мэдэх эрх-Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн 2 дугаар зарчимд (олон улсын стандартын цуврал) албан нууцыг хадгалах заншил, “нууцаа” хаалттай байлгадаг тогтсон хэв маягийг эвдсэн хэд хэдэн механизмыг хуулиар хангаж өгөх ёстой талаар тусгайлан заасан нь ач холбогдолтой байна. Тухайлбал, төрийн байгууллагууд өөрийн ажилтнуудад зориулж мэдээллийн эрх чөлөөний тухай сургалт зохион байгуулж байх явдал. Уг сургалт нь мэдээллийн эрх

чөлөөний хамрах хүрээ, ач холбогдол, мэдээлэл олж авах журам, дараалал, мэдээллийн эх сурвалжийг хэрхэн үр дүнтэй хадгалах, олж авах, мэдээлэгчийг хамгаалах хүрээ, ямар төрлийн мэдээллийг тухайн байгууллага хэвлэн нийтлэх үүрэгтэй зэрэг асуудлыг хөндөх юм.

Судалгаанд оролцсон төрийн байгууллагууд нь хэнд, ямар тохиолдолд мэдээлэл өгдөг вэ гэсэн асуултад дараахь байдлаар хариулсан байна.

Хүснэгт-8

№	Хариултын хувилбар	Төрийн байгууллага /тоо/
1.	Төрийн байгууллага мэдээлэл хүссэн тохиолдолд	39
2.	Төрийн албан хаагч албан шугамаар хандсан үед	35
3.	Төрийн бус болон хувийн байгууллага мэдээлэл авах хүсэлтээ албан ёсоор гаргасан тохиолдолд	35
4.	Иргэн хүн зорилгоо тайлбарласны үндсэн дээр	32
5.	Мэдээллийн агуулга, тоо, хэмжээ, багтаамжаас хамаарч зорилгоо тайлбарласан тохиолдолд иргэн хүнд	20
6.	Зөвхөн удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр жирийн иргэнд	13
7.	Иргэн хүн татвар төлөгчийн хувьд	11
8.	Хувийн журмаар гуйж, туслалцаа хүссэн тохиолдолд	9

Иргэн хүн мэдээллийг ашиглах, хэрэглэх зорилгоо тайлбарласан нөхцөлд мэдээллийг олж авах боломжтой гэдэг нь тодорхой хэмжээгээр “цензур” байгааг харуулж байгаа хэрэг. Судалгаанд хамрагдсан 47 байгууллагуудаас 8 байгууллага мэдээллийг төлбөртэй өгдөг бол үлдсэн байгууллагууд нь ямар нэг төлбөр, хураамж авдаггүй байна, харин төлбөр авдаг эдгээр 8 байгууллагууд төлбөр нь үйлчилгээний зардлыг бүрэн нөхөж чаддаггүй гэжээ.


Мэдээлэл авахад зохих хэмжээний төлбөр, хураамж байж болно. Энэ нь мэдээлэл өгөхөд гарах шууд зардлыг нөхөх хэмжээнд байх нь зүйтэй. Их хэмжээний шууд зардал гарах тохиолдолд тодорхой хувийг иргэнээс гаргуулах, үлдэх хувийг нь төр даадаг байх нь тохиромжтой юм. 19 дүгээр зүйл байгууллагаас боловсруулсан Олон нийтийн мэдэх эрх-Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн 6 дахь зарчимд (олон улсын стандартын цуврал) Хураамжийн талаар заасан байна. Уг зарчимд хувь хүмүүс мэдээлэл авах хүсэлт гаргахад өндөр үнэ саад болох ёсгүй гэж тэмдэглэсэн байдаг. Мөн төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийг олж авах үнэ төлбөр нь

хүсэлт гаргахаар шийдсэн хувь хүн төлөх боломжгүй өндөр үнэтэй байх ёсгүй. Үүнд мэдээллийн эрх чөлөөний хуулийн хамгийн гол цөм бол мэдээлэлд нээлттэй хүрэх явдлыг хөхүүлэн дэмжих явдал юм. Нээлттэй байхын хожим өгөх үр ашиг нь үнэ төлбөрөөс хамаагүй илүү байдаг гэдэг нь аль хэдийнээ нотлогдсон зүйл юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2001 оны 22 тоот тушаалаар “Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, түүнд гарсан мэдээ, мэдээллийн дагуу ажиллах журам” батлан гаргасан нь тус яам болон сайдынх нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг агентлагууд, зөвлөл, албад хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хэвлэл, мэдээллээр гарсан мэдээ, мэдээллийн дагуу зохиох ажлыг журамлах тухай тушаал гаргасан байна. Энэ нь тус яам болон цагдаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, гал, оюуны өмч, шүүхийн ерөнхий зөвлөл, иргэний бүртгэл мэдээлэл, хилийн цэрэг, архив, үл хөдлөх эд хөрөнгө, гадаадын иргэдийн асуудал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн бүхий л хүрээнд хэрэгцээтэй мэдээллээ 3 хоногийн дотор олж авах, шаардлагатай тохиолдолд эх хувьтай нь танилцах боломжийг нь нээж өгсөн байна. Энэ нь зөвхөн нэг сайдын эрхлэх асуудлын хүрээнд л шийдэгдсэн хэвлэл, мэдээллийнхэний хамгийн эрэлттэй атлаа мэдээлэл олж авахад бэрхшээлтэй салбарт давуу боломж олгогдсон байна. Гэхдээ энэ нь асуудлыг шийдвэрлэсэн гэсэн үг биш юм.

2. Байгууллагын нууцын тухай Монгол Улсын хуулиар байгууллагын нууцыг 2 журмаар тогтоохоор заасан байна. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт байгууллагын нууцыг хуулиар тогтоох тухай, харин 2 дахь хэсэгт байгууллага өөрөө нууцаа тогтоох талаар заажээ.

Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 2 дахь заалтад “**байгууллагын нууц**” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд, тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг, мөн зүйлийн 2 дахь хэсэгт байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-




шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болох талаар заажээ.

Энэ хуулиар байгууллагын нууцад хамааруулан хамгаалбал зохих мэдээллийг өргөн хүрээтэй, харин уг хуулийн 6 дугаар зүйлд зааснаар байгууллагын нууцад хамаарахгүй мэдээллийн хүрээ хэт явцуу байна. Мэдээллийн эрх чөлөөний үндсэн зарчим, олон нийтийн мэдэх эрхийн үүднээс ил тод, нээлттэй байх мэдээлэл нь өргөн хүрээтэй, харин нууцад хамаарах мэдээллийн хүрээ явцуу түвшинд байх нь тохиромжтой.

Уг хуулиар байгууллагын нууцыг ил болгох буюу байгууллагын нууцыг хамгаалалтаас гаргах тухай асуудлыг орхигдуулсан байна.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт ил байдаг билээ. Гэтэл байгууллагынхаа нууцын жагсаалтыг нууцлах хандлага бодитойгоор оршиж байна. Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудаас 12 нь байгууллагынхаа нууцын жагсаалт, нууцаа хадгалах, хамгаалах журмаа батлаагүй байна. (Хүснэгт-9) Түүнчлэн зарим байгууллагууд байгууллагынхаа нууцын жагсаалтыг байгууллагын нууцад (23 байгууллага) оруулж байгаа нь буруу юм. Учир нь байгууллагын нууцын жагсаалт ил тод байвал ямар мэдээлэл нь байгууллагын нууцад орж байгааг хүн бүр мэдэх боломжтой, тийм учраас нууцын жагсаалтад орсон мэдээллийг авах хүсэлтийг гаргахгүй нь ойлгомжтой. Харин нууцын жагсаалт нь нууц байвал, эрх бүхий этгээд ямар нэг нэгэн мэдээллийг өгөхгүй байх санаа зоригийн үүднээс тухайн мэдээлэл нь хэдийгээр байгууллагын нууцад хамаарахгүй байсан ч байгууллагын нууц гэсэн үндэслэлээр өгөхөөс татгалзах боломжыг олгох болно. Байгууллагын нууцын жагсаалт нь нууц биш, харин түүнийг хадгалах, хамгаалах журам нь нууц байх нь тохиромжтой юм. Судалгаанд хамрагдсан нийт байгууллагаас 14 байгууллага нууцын жагсаалт байгууллагын нууцад ордоггүй гэж хариулжээ. Өнөөдөр байгууллагын нууцын жагсаалтыг нэг хэсэг нь байгууллагын нууцад хамааруулж байхад, нөгөө хэсэг нь нууцад хамааруулахгүй байх гэсэн хоёр практик байна.

Дүгнэн үзвэл, байгууллагын нууцын жагсаалт, нууцаа хадгалах, хамгаалах журмаа батлаагүй байгаа байдал, баталсан байгууллагууд нь нууцын жагсаалтаа байгууллагын нууцад хамааруулж байгаа нь мэдээлэл чөлөөтэй хүртэх эрхээ хэрэгжүүлэх сөргөөр нөлөөлж байна.



Хүснэгт-9

№	Нэр	Байгууллагынхаа нууцын жагсаалтыг баталсан эсэх		Байгууллагынхаа нууцыг хадгалах, хамгаалах журам гаргасан эсэх		Байгууллагын нууцын жагсаалт нь байгууллагын нууцад ордог эсэх		Байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах журам нь байгууллагын нууцад хамаардаг эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1.	Төрийн байгууллагууд	32	12	33	12	23	14	26	12

Байгууллагын нууцын жагсаалтад ямар ямар мэдээлэл ордог талаар судалгаа хийж үзэхэд байгууллагын нууцын жагсаалтаа нууц гэж үздэг байгууллагаас ийм мэдээлэл авах боломжгүй олноогүй бөгөөд тэдгээрээс цөөн хэдэн байгууллага энэ асуултад хариулсан юм, харин байгууллагын нууцын жагсаалт нь нууц биш, нээлттэй гэж үздэг байгууллагууд энэ асуултад тодорхой хариулсан болно. Тухайлбал,

Хүснэгт-10

№	Байгууллагын нэр	Байгууллагын нууцад хамаардаг мэдээлэл
1.	Гаалийн ерөнхий газар	Эдийн засгийн тагнуулын мэдээ, бизнесийн нууц, үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу нууцалсан мэдээлэл гэх мэт
2.	Үндэсний Статистикийн Газар	Төрийн болон байгууллага, хувь хүний нууц, аж ахуйн нэгж, байгууллагын ганцаарчилсан тоо, мэдээ, боловсруулалтын шатанд байгаа статистикийн мэдээлэл гэх мэт
3.	Улсын нөөцийн газар	Улсын нөөцийн хэмжээ, нэр төрөл, байршил, санхүүгийн баримт бичиг гэх мэт
4.	Санхүү Эдийн Засгийн Яам	Өрийн судалгаа, төсөв, хөрөнгө оруулалт, тендерийн материал, төсөл, хөтөлбөрийн материал, гэрээ, хэлэлцээр гэх мэт.
5.	ҮТЕГ	Татвар төлөгчийн талаарх мэдээлэл гэх мэт.
6.	Иргэний Нисэхийн Ерөнхий Газар	Гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээр /5-10 жил/, улсын онц чухал объектын хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай баримт, сантехник, дулаан, цахилгаан сүлжээний зураг схем, байгууллагын санхүүжилттэй холбоотой зарим мэдээ, тендерийн материал, онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө, журам, үйл ажиллагааны зохион байгуулалт, холбоо, зарлан мэдээллийн ажиллагааны зохион байгуулалт, код, кабель шугамын нэгдсэн сүлжээ, ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын протокол, холбогдох материал, мэргэжлийн үнэмлэх гэх мэт.
7.	УЕПГ	Шалгагдаж байгаа эрүүгийн хэргийн материал, гүйцэтгэх ажилтай холбоотой үйл ажиллагааны тухай мэдээлэл гэх мэт.
8.	Авто замын газар	Төрийн нууц болон байгууллагын нууц

		тендерийн баримт бичиг гэх мэт.
9.	Түлш, эрчим хүчний ерөнхий газар	Эрчим хүчний системийн 220/110/35 кв-ын цахилгааны холболтын ерөнхий схем, удирдлагын шийдвэр гаргахад зориулж бэлтгэсэн санхүүгийн материал гэх мэт.
10.	ДБЯ	Төр засгийн нууц тогтоол, шийдвэр, монгол орны газрын зураг, иргэний хамгаалалтын дайчилгааны төлөвлөгөө гэх мэт.
11.	Гал түймэртэй тэмцэх газар	Гал унтраах хүн хүч, хэрэгслийн байршил, орон тоо, тооцоо, харуулын томилонт гэх мэт.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар байгууллагын нууцын тухай журмаа 2000 оны 3 дугаар сарын 10-нд баталсан байна. Уг журмаар Засаг даргын Тамгын газрын нууц гэдэгт Тамгын газрын үйл ажиллагааны онцлогтой холбоотой нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, албан хаагчдын хувийн хэргийг ойлгохоор заажээ. Байгууллагын нууцад 8 төрлийн мэдээлэл, баримт бичгийг оруулахаар заасан байна. Үүнд:

1. Дүүргийн засаг даргын захирамж;
2. Төрийн албан хаагчдын хувийн хэрэг;
3. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөний тайлан;
4. Төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын талаар ирсэн мэдээлэл;
5. Иргэдээс хувийн асуудлаар ирсэн өргөдөл, гомдол;
6. Цэрэг иргэний хамгаалалтын тоо бүртгэл;
7. Дайчилгааны ач холбогдолтой баримт бичиг;
8. Иргэний хамгаалалтын ажлын төлөвлөгөө.

Уг журмаар дүүргийн засаг даргын захирамжийг байгууллагын нууцад хамааруулж байгаа нь буруу юм. Энд ялгамжтай хандах нь зүйтэй. Харин зөвхөн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах захирамж нь байгууллагын нууцад хамаарч болно.

3. Төрийн байгууллагаас мэдээлэл авахад даргын зөвшөөрөл авдаг явдал байна. Энэ бол иргэдийн мэдээлэл олж авах эрхэд хаалт болж буй нэг гол шалтгаан юм. Төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалснаас бусад мэдээлэл ил тод, нээлттэй байх талаар Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт "Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан

хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж заасан байдаг. Нэгэнт хуулиар ил тод, нээлттэй байх нь баталгаажсан хийгээд нууцын жагсаалтад ороогүй мэдээллийг авах хүсэлт иргэн хүн гаргасан бол даргын зөвшөөрөл авах шаардлага байхгүй юм. Төрийн байгууллагын албан хаагч иргэдэд мэдээлэл өгөхдөө даргын зөвшөөрөл авдаг эсэх талаар судалгаанд оролцогч төрийн байгууллагаас асуулга авсан юм. Судалгаанд оролцогч 30 /байгууллага/ зөвшөөрөл авдаггүй гэж хариулсан бол, 12 /байгууллага/ нь даргын зөвшөөрөл авдаг гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан 47 байгууллагын 17 байгууллага нь ямар нэг хэмжээгээр 2002 онд иргэдийн гаргасан мэдээлэл авах хүсэлт, хүсэлтэд хариу өгсөн талаар ямар нэгэн тоо, бүртгэлтэй байсан юм. Бусад байгууллагуудын хувьд мэдээлэл авах хүсэлт гаргасан болон өгсөн хүний талаар ямар нэг бүртгэл, тооцоо байхгүйгээс шалтгаалан энэхүү асуултад хариулах боломжгүй гэх зэргээс хариулсан болно. Жишээ нь: Улсын нийгмийн халамжийн газар гэхэд иргэд байнга мэдээлэл авч байдаг, гэхдээ тодорхой тоо байхгүй гэж хариулсан.

Үндэсний статистикийн газар гэхэд 2002 онд давхардсан тоогоор 441 иргэнд, үүнээс гадна захиалгат буюу төлбөртэй мэдээллийг 864 байгууллагад, төр засгийн 1654 байгууллага, аймаг, нийслэлийн 108, албан бичгээр 6, гадаадын 100 байгууллагад гэх зэргээр нийт 3173 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгсөн байна.

Иргэд төрийн байгууллагаас ихэвчлэн ямар төрлийн мэдээлэл авах хүсэлт гаргадаг талаар судалгаа хийхэд дараахь төрлийн мэдээлэл авах хүсэлт гаргадаг нь харагдаж байна. Үүнд:

УИИМН
СУДАЛГААНЫ САН
Хүснэгт-11

№	Байгууллагын нэр	Иргэд ямар төрлийн мэдээлэл авах хүсэлт гаргадаг болох
1.	ХУД-ийн ЗДТГ	Шинээр гарсан хууль тогтоомжийн талаар
2.	БСШУЯ	Сургалтын төлбөр, түүнээс чөлөөлүүлэхэд баримтлах эрх зүйн акт, тодорхой үйл ажиллагаатай тусгай зөвшөөрөл, мөрдөгдөж байгаа болон шинээр гарсан хууль тогтоомжийн тухай

3.	Гаалийн Ерөнхий Газар	Гаалийн бүрдүүлэлтийн журам, татварын хувь хэмжээ
4.	Эрүүл мэндий Яам	Хууль тогтоомж, явуулж буй үйл ажиллагааны тухай
5.	Үндэсний Статистикийн газар	Эдийн засаг, нийгмийн тухай статистикийн бүх мэдээлэл
6.	Үйлдвэр худалдааны яам	Иргэд, оюутан нар үйлдвэр, худалдааны салбарын мэдээлэл, тоо, статистик мэдээ, экспорт, импортын мэдээ, нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлийн мэдээ, бодлого, зохицуулалт гэх мэт
7.	ТЕГ	Хэлмэгдүүлэлтийн үеийн мэдээлэл
8.	НХХЯ	Тэтгэвэр, цалин, гадаадад ажил эрхлэх, хөдөлмөр эрхлэх талаар
9.	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой мэдээлэл
10.	Улсын нийгмийн халамжийн газар	Тэтгэвэр, тэтгэмжийн талаар, хөнгөлөлт, үйлчилгээний талаар, тусламж үзүүлдэг байгууллагуудын талаар, протез зэрэг хэрэгслийн талаар, асрагч, халамжийн үйлчилгээний тухай
11.	ГХОГХА	Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл
12.	Авто замын Газар	Хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар
13.	Газрын тосны хэрэг эрхлэх газар	Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар судалгааны дүн, тайлан
14.	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв	Иргэн өөртэйгээ холбоотой иргэний бүртгэлийн талаар, зарим иргэний хаягийн лавлагаа
15.	ХЗДХЯ	өргөдөл, гомдол, мэдээлэл, хууль тогтоомжийн талаар
16.	БХЯ	Цэргийн албан хаагчдын /офицер, ахлагч нарын/ тэтгэвэр, тэтгэмжийн тухай асуудлаар мөн гэрээт болон дүйцүүлэн цэргийн алба хаах тухай асуудлаар тодруулга авах
17.	Улсын иргэний хамгаалалтын газар	Гамшиг, ослын тухай мэдээлэл

Манай улсад төрийн байгууллага, албан хаагчдаас иргэдийн мэдээлэл олж авах боломжыг нэмэгдүүлэхэд цаашид юу хийх шаардлагатай байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчид дараахь байдлаар хариулжээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт-12

№	Хариултын хувилбар	Төрийн байгууллага /тоо/
1.	Эрх зүйн орчин бүрдүүлэх	17
2.	Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байгаа тул иргэдэд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа сайн хийх	21
3.	Төрийн байгууллагын үйл ажиллагааг одоогийн байгаага төвшнөөс илүү ил тод, нээлттэй болгох	17
4.	Эрх зүйн зохицуулалт шаардлагагүй, харин зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгтэй	10

Дүгнэн үзвэл, судалгаанд хамрагдсан төрийн 21 байгууллага нь төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байгаа тул иргэдэд энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа сайн хийх хэрэгтэй гэж хариулсан нь төрийн байгууллагууд ил тод, нээлттэй байх чиглэлээр цөөнгүй ажил зохион байгуулж байгааг харуулж буй хэрэг юм. Түүнчлэн энэ асуудлаар иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил дутагдалтай байгааг давхар илтгэж байна.

Гэхдээ энэ нь хангалттай бус, цаашид мэдээлэл олж авах эрхийг хангахын тулд 1.Эрх зүйн орчин бүрдүүлэх (17 байгууллага), 2.Төрийн байгууллагын үйл ажиллагааг одоогийн байгаа төвшинөөс илүү ил тод, нээлттэй болгох шаардлагатай (17 байгууллага) гэж хариулжээ.

Харин судалгаанд оролцсон иргэнд мэдээлэл олж авах эрхийг цаашид амьдралд бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд дараахь зүйлийг хийх хэрэгтэй гэж үзжээ. Үүнд:

Хүснэгт-13

	Цаашид авах шаардлагатай арга хэмжээ	Иргэний тоо
1.	Төрийн байгууллагууд, албан хаагч нарт уг эрхийн талаар сургалт явуулах	51
2.	Төрийн байгууллагад мэдээлэл өгдөг албан хаагчийг ажиллуулах	29
3.	Эрх зүйн орчинг бүрдүүлэх	50
4.	Олон нийтэд хандсан энэ эрхийн талаар сургалт, мэдээлэл, сурталчилгаа явуулах	56
5.	Ерөнхий сайд энэ талаар засгийн газрын тогтоол гаргах хэрэгтэй	12
6.	Яамдаас эхлээд мэдээллээ чөлөөтэй болгох хэрэгтэй	31
7.	Цэнзургүй мэдээллийг түгээх,	1
8.	Үндэсний Радио, телевизийг Засгийн газрын мэдлээс гаргах	1
9.	Телевиз, радиогоор сурталчлах	1
10.	Хөдөөгийн засаг захиргаанаас	1



ХОЁР.СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ОЛЖ АВАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэрэг, маргааныг шүүхээр шийдвэрлэж буй практик

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нээлттэй нийгмийн нэг тулгуур болохын хувьд ардчилсан нийгэмд өөрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байдаг. Бусдын өмнө хүлээх үүрэгтэй, шударга ёс, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь нээлттэй нийгэм дэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны нэг гол шинж мөн. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд харшлах мэдээ, сэлт нийгэмд тараах, түүнийг бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор ашиглах нь чөлөөт хэвлэлийн үүрэг, ач холбогдлыг бууруулж, сулруулахад хүргэх ноцтой үр дагавартай билээ.

Нийслэлийн зургаан дүүргийн шүүхэд 1999 оны 1 сарын 1-нээс 2001 оны 11 сарын 01-ны өдрийг хүртэл хугацаанд буюу энэ 3 жилийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр хувь хүн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай иргэний маргаан 79 (цаашид “нийт иргэний хэрэг маргаан” гэх), “гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан” гэмт хэрэг 4 бүгд 83 хэрэг, маргааныг шийдвэрлэгдсэн байна.⁶


Энэхүү 79 иргэний хэргийн 47 хэрэгт шүүх хариуцагчаар татагдан орсон хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэлээр дамжуулан гутаасан гэм буруутай гэж тогтоожээ. Энэ нь нийт иргэний хэргийн 59.4 хувь байх бөгөөд нийт иргэний хэргийн 29.1 хувь буюу 23 хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч эвлэрсэн байна.

⁶ “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, гүтгэсэн хэрэг, маргааныг шүүхэд шийдвэрлэсэн талаарх судалгааны тайлан, “Сэтгүүлч ба хууль”, 2001 он, УБ.,

Энэ 3 жилийн хугацаанд гарсан энэ төрлийн нийт иргэний маргааны тухайд хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутайд тооцогдсон нь 88.6 хувь (Хүснэгт-1) болж байна.

Үүнээс гадна нэг иргэний хэрэгт (1.2 хувь) бусдын нэр төрийг гутаасан мэдээлэл нийтэлсэн сонин хэвлэл биш уул мэдээллийг зориуд нийтлүүлсэн этгээдийг буруутган хариуцагчаар татсан практик шүүхийн үйл ажиллагаанд үзэгдэж байгаа нь эргэлзээтэй юм. Жишээлбэл, 2000 онд Баянгол дүүргийн шүүх иргэн Дарь.Сүхбаатарын нэр төрөө сэргээлгэх нэхэмжлэлтэй иргэний хэрэгт шүүх уул мэдээллийг (ярилцлагыг) нийтэлсэн "Хүмүүс", "Өдрийн сонин" сонинуудыг биш харин ярилцлага өгсөн Б.Билэгт (МРТХЭГ-ын дарга)-ийг хариуцагчаар тогтоож, тэр ярилцлага нь бусдын нэр төрийг гутаасан гэж шүүх үзсэн байна. Шүүхээс нэр төрийг нь сэргээсэн тухай мэдээ нийтлэхийг дээрх сонинуудад үүрэг болгосон нь "гэм буруу"-г хуваасан мэт болгож хоёрдуулжээ. Шүүхийн эл шийдвэр "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 заалтын утга санаатай нийцэхгүй байна. Гэвч үүнийг шүүх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эвлэрэнгүй хандсан гэж үзэхээс илүү нэхэмжлэгч нь уг ярилцлагыг өгсөн хүнээс нэр төрөө сэргээхийг шаардсан тул тухайн тохиолдолд шүүх хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг хариуцлагаас чөлөөлж нэхэмжлэлийн шаардлагыг хангасан гэж үзэх үндэстэй болов уу.

Харин нийт иргэний хэргийн 5.1 хувь буюу 4 хэрэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзжээ. Тухайлбал, "Засгийн газрын мэдээ" сонины 1997 оны №72-т "Хүний гараар могой бариулах гэв үү" гэсэн нийтлэлээр "миний бөгөөд өрх гэрийн нэр хүнийг гутаасан" гэж иргэн Б.Юмчин 1998 оны 11 сарын 23 нд Сүхбаатар дүүргийн шүүхэд "Засгийн газрын мэдээ" сониноос нэр төрөө сэргээлгэх, 8 сая төгрөг нэхэмжилсэн ч уг сонины газар татан буугдсанаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан байна.



Энэ тухай 1999 оны 01 сарын 28-нд шүүгч захирамж гаргажээ. Эл тохиолдолд нэхэмжлэгч нь эрх залгамжлагчид нэхэмжлэл гаргах эрхээ эдлээгүйтэй холбоотой байж болох юм.

Мөн 1999 оны 01 сарын 29 ны өдөр иргэн Ж.Самбуу "Завсарлага" сонины 1998 оны №77-78, "Тэжээсэн бяруу тэрэг эвдэх вий", "Лю овогт Самбуугийнхан аюул тарих вий" гэсэн нийтлэлээр нэр төр гутаасан гэж 30 сая

төгрөг нэхэмжилсэн ч 1999 оны 5 сард нэхэмжлэгч "энэ сарын зурхайд бүү марга гэсэн" гэж нэхэмжлэлээсээ татгалзсан тул шүүгч захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Эцэст нь дээрхи 79 маргааны 5.1 хувь буюу зөвхөн 4 хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруугүй өөрөөр хэлбэл, нийтлэл нь бусдын нэр төрийг гутаагаагүй байна гэж шүүх тогтоосныг үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүний эрх, ашиг сонирхлыг хөсөрдүүлдэг нь маргаангүй аж.

Хүснэгт-14

№	Иргэний хэргийг шүүх шийдвэрлэсэн байдал	Хэргийн тоо	Хувь
1.	Хариуцагч буруутай	47	59.5
2.	Хариуцагч буруугаа хүлээж нэхэмжлэгчтэй эвлэрсэнийг баталсан	23	29.1
3.	Хариуцагч гэм буруугүй	4	5.1
4.	Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан	4	5.1
5.	Хариуцагчаар татаагүй боловч нийтэлсэн ярилцлага нь бусдын нэр төрийг гутаасан	1	1.2
6.	Нийт	79	100

Мөн хугацаанд шүүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гүтгэсэн тухай 4 эрүүгийн хэргийг шийдвэрлэсэн нь 6 дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг, маргааны 4.8 хувь болжээ. Тэр 4 хэрэгт 6 сэтгүүлчийг гэм буруутайд тооцон Эрүүгийн хуульд зааснаар ял шийтгэжээ.

Эрүүгийн хэрэгт хорих ял шийтгүүлсэн 1 сэтгүүлч байгаа бөгөөд түүнд оноосон хорих ялыг тэнсэж хянан харгалзах хугацаа тогтоожээ. Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд шүүхээс хорих ял биечлэн эдлэхээр шийтгүүлсэн сэтгүүлч байхгүй гэсэн үг юм.

Эрүүгийн хоёр хэрэг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн ч анхан шатны шүүхийн шийдвэр хэвээр батлагдсан бөгөөд "Бөх", "Буухиа мэдээ", "Хувийн амьдрал", "Шар мэдээ" зэрэг сонинуудаар хохирогчийг гүтгэж, доромжилсон мэдээг тараажээ. Тухайлбал, Сэтгүүлч Ж.Заяабаатар "Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди нь ээмэг, бөгж, алмаазан шигтгээтэй

зүүлт авсан” гэж бичиж Сүхбаатар дүүргийн шүүхийн 1999 оны 05 сарын 26-ны 339 тоот таслан шийдвэрлэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 117-р зүйлийн 2 хэсэгт⁷ зааснаар 1 жил хорих ял оноож, уг ялыг мөн хугацаагаар тэнсэн харгалзахаар шийдвэрлэсэн байна. Мөн 1999 онд “Шар мэдээ” сонинд “эр, эм хоёр хурьцал үйлдэж наалдсан ноцтой хэрэг гарч, салгуулав” гэсэн нийтлэл бичсэн сэтгүүлч Б.Ойдов, Ж.Өлзийсайхан нар Эрүүгийн хуулийн 117-р зүйлийн 2 хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээжээ. “Шар сонин” 2001 оны №13-т “МНТ”-ын Ерөнхийлөгч залилан хийжээ.”, “Хувийн амьдрал”, “Буухиа мэдээ” сонинд “МНХ-ын тэргүүн шалгагдсаар байна”, “Нямдорж сайдын зөвлөлийн гишүүн гэмт хэрэгт шалгагдаж эхэллээ” гэж бичжээ. Монголын Нотариатчидын Танхимын Ерөнхийлөгч А.Оюунчимэг хэвлэлээр гүтгэсэн гэмт хэрэгт холбогдуулан өргөдөл гаргаж, улмаар “Итгэлт-Оюу” ХХК-ний сэтгүүлч М.Халиунбат, “Шар сонин”-ы сэтгүүлч Д.Сүхбат нар тус бүр 80000 төгрөгөөр торгуулах ял шийтгүүлж, торгох ялыг биелүүлэхгүй бол хорих ялаар солих тухай хуулийг хэрэглэх талаар анхааруулсан байдаг байна.

Дээр бүлэглэж үзсэн 83 хэрэг, маргааныг тархацаар нь буюу дүүрэг тус бүрээр нь ангилж үзвэл энэ төрлийн бүх хэрэг, маргааны (Хүснэгт-2) 62.6 хувийг Сүхбаатар дүүргийн шүүх, 22.8 хувийг Чингэлтэй дүүргийн шүүх, 9.6 хувийг Баянзүрх дүүргийн шүүх, 3.6 хувийг Баянгол дүүргийн шүүх, 1.2 хувь Сонгионхайран дүүргийн шүүх тус тус хянан шийдвэрлэсэн байна. Энэ нь хариуцагч болох хэвлэл мэдээллийн хэрэгслийн олонхи тус хоёр дүүрэгт оршин үйл ажиллагаа явуулдагаас хамааралтай юм.

Хүснэгт-15

	Шүүх	1999 он		2000 он		2001 он		Нийт хэрэг
		И.Х ⁸	Э.Х ⁹	И.Х	Э.Х	И.Х	Э.Х	
1.	Сүхбаатар дүүрэг	21	3	24		4		52
2.	Чингэлтэй дүүрэг	6		8		4	1	19
3.	Баянзүрх дүүрэг	3		5				8
4.	Сонгинохайрхан дүүрэг			1				1

⁷ Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшируулан тараасан гэмт хэрэг

⁸ Иргэний хэрэг

⁹ Эрүүгийн хэрэг

5.	Баянгол дүүрэг			1		2		3
6.	Хан-Уул дүүрэг							0
7.	нийт	30	3	39	0	10	1	83

Эдгээр хэрэг, маргааныг цаг хугацаа буюу он, оноор нь авч үзвэл, 1999 онд 30 иргэний хэрэг, 3 эрүүгийн хэрэг, 2000 онд 39 иргэний хэрэг, 2001 онд 10 иргэний хэрэг, 1 эрүүгийн хэрэг тус бүр шийдвэрлэгдсэн байна. Судлаач Д.Гантуг, Ч.Энхтуяа нарын хийсэн судалгаанаас 1991-1998 он хүртлэх тоо баримтыг өөрсдийн хийсэн сүүлийн 3 жилийн тоо баримттай нэгтгэн 1991-2001 оны 11 сарын 01 хүртлэх сүүлийн 10 жил 10 сарын хугацаанд гарсан энэ төрлийн хэрэг, маргааны талаарх тоог хүснэгт-16 үзүүлэв.

Хүснэгт-16

Он Хэрэг	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001. 11.01	Нийт хэрэг
Иргэний хэрэг	7	5	5	3	8	13	23	31	30	39	10	174
Эрүүгийн хэрэг									3		1	4
"	7	5	5	3	8	13	23	31	33	39	11	178

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг талаар бусдын нэр төрийг гутаах, нөгөө талаар нэр төрөө шүүхээр сэргээлгэх явдал 1995 оноос 2001 он хүртэл жил дараалан өсч, 1996 онд 13, 1997 онд 23, 1998 онд 31, 1999 онд 33, 2000 онд 39 байснаа 2001 оноос мэдэгдэхүйц буурч 11 болжээ. Гэвч ганц жилийн бууралтыг тогтвортой хандлага гэж үзэхэд хараахан учир дутагдалтай юм. Энэ төрлийн нилээд хэрэг, маргаан шүүхийн шатанд өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй үлдсэнийг судалгаа харуулсныг бодолцвол тийм дүгнэлт хийхэд эртдэх болно. Мөн энэ төрлийн хэрэг, маргааны тоо буурч байна гэж үзэх үндэсгүй талаар Улсын Дээд шүүхийн судалгаанд¹⁰ ч тусгагдсан байна. Дурьдсан "1995-1997 онд нэр төр гутаасан гэх 69 нэхэмжлэл, 1999 онд 140 хэрэг шийдвэрлэснээс үзэхэд энэ төрлийн хэргийн

¹⁰ Дээд шүүхийн мэдээлэл 2001/01, 34,35 дахь тал

“тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна” гэсэн нь бидний судалгаатай дүйж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслэл нь үзэл бодлын чөлөөт индэр болохын хувьд нийгэмд бугшиж буй аливаа бусармаг явдлыг илчлэн олны сонорт хүргэж нийгэмд шүүмжлэлт, эрүүл саруул уур амьсгалыг бий болгохын төлөө тэмцдэг.

Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийг нийтлэхээс эхлэн шүүхэд өөрийгөө хамгаалах зэрэг аливаа асуудалд нухацтай хандах, хуульд нийцүүлэх шаардлага гарч ирж байгаа юм.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үүнд анхаарал тавьдаггүй нь энэхүү судалгааны тоо, баримтаас тодорхой ажиглагдах бөгөөд асуудлыг хөндөхдөө дараахь нийтлэг зөрчил гаргадаг байна.

Зөрчил нь олон янзын шалтгаантай нь судалгаанаас харагдав.

- Мэдээллийн эх сурвалжыг нягталж шалгахгүйгээр нийтлэх,
- Шүүх эрх мэдлийн хүрээнд эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэргийн талаар, түүнчлэн шалгагдаж байгаа хүний талаар бичихдээ гэм буруутай эсэхэд баримт өгч шүүхийг “орлодог”,
- Мэдээллийг авснаас хойш хугацаа алдаж үзэгдэл юмс хооронд гарсан эрс өөрчлөлтийг тусгахгүйгээр нийтлэх зэргээр мэдээллийн шуурхай байх шаардлагыг гажуудуулах,
- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийтэлж буй мэдээллийн үнэн зөвийг хайхрахгүйгээр бусдын худал ташаа мэдээ нийтлэх,
- Аль нэг мэдээллийн хэрэгслэлийн нийтэлээс буруу ташаа мэдээг хуулбарлан нийтлэх,
- Өөрийн сонинг сурталчлан зарлан мэдээлэхдээ сониноо борлуулах шаардлагад хөтлөгдөн бусдын нэр төрийг гутаасан, баримт нотолгоогүй, үндэслэлгүй мэдээг телевиз, радиогоор тараах.

Түүнчлэн шүүхэд “нотлох баримт нь бий, ярилцлага өгсөн хүн нь байгаа, тэр хүн өөрөө хариуцна гэсэн” гэх, “нийтлэлийн хариуцлагыг сэтгүүлч хариуцана” гэсэн бичигдээгүй хууль сониныхонд үйлчилдэг”, “ийм сайхан залуухан хүүхний биенд эвлүүлэг хийсэн байхад юундаа нэр төр нь гутдаг байна аа” гэх зэрэг хариу тайлбар хийх бөгөөд харин шүүх хуралдааны үеэр эвлэрэх, уучлал гуйх зэргээр буруугаа хүлээж “нэгэнт урьд нь ингээд

нийтэлчихсэн юм чинь одоо яаж залруулж бичих юм вэ эвгүй шүү дээ, өөр сониноор залрууллага хийе”, “энэ мэдээллийг нийтлэхдээ нэхэмжлэгчийн нэр төрийг гутаах зорилго агуулаагүй” гэх зэргээр тайлбар өгдөг байна.

Өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаалгасан гэж үзэж нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан иргэн Д.Сүхбаатарын нэхэмжлэл, тайлбар, хэргийн материалыг судлан дор дурдсан дүгнэлтийг хийсэн болно.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай Монгол Улсын хуулийн (1998 он) 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт **“Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.”** гэж заасан байдаг. Гэтэл “Сэрүүлэг” сонин нь өөрийн нийтэлж буй мэдээллийнхээ үнэн зөвийг үл хайхран иргэн Б.Энхбаярын ярьсан худал ташаа, бодит байдалд үл нийцэх, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг /жүжигчин/ гутаасан агуулгатай, мөн Хувь хүний нууцын тухай хуулиар гэр бүлийн нууц бүхий мэдээллийг эх сурвалжыг нь шалгаж нягтлахгүйгээр, зөвшөөрөлгүй, хууль зөрчин нийтэлсэн явдал нь Д.Сүхбаатарын нэр хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзэж болохоор байна.Тухайлбал:

“Сэрүүлэг” сонин нь 2003 оны 13 дахь дугаартаа **“Ацаг шүдний зөрөө”** киноны Намжил буюу жүжигчин Д.Сүхбаатар үеэл дүүтэйгээ байр булаалцалдан эцгийнхээ шарилыг хөндөх гэж байна.” гэсэн гарчигийн дор Б.Энхбаярын өгсөн “Өвөө минь надад байраа гэрээсэлсэн атал Сүхээ ах булаацалдан намайг эрүүгийн хэрэгт гүтгэн шоронд хатаахаар хөөцөлдөж байна.” гэсэн ярилцлагад илт худал, буруу ташаа, үндэслэлгүй мэдээлэл нийтэлсэн байх бөгөөд энэхүү ярилцлагад нэр төр, алдар хүндийг гутаасан агуулга бүхий дор дурдсан мэдээлэл нийтэлсэн байна. Үүнд:

1. “Гэтэл өвөөг нутаглуулж амжаагүй шахам байхаас л үр хүүхдүүд нь над руу дайрч байр суллаж өг. Байрны бичиг баримт гаргаж өг тэгэхгүй бол ална хядна гэж айлгаж сүрдүүлж эхэлсэн.”;

2. “Өвөөг нас барсны орой хүү Сүхбаатар нь над руу утасдаад “Ах

аа аавын байрны ордерийг өгчих. Аав надад байраа өгнө гэж байсан юм.” гэхээр нь миний дургүй хүрсэн л дээ. Эцгийнхээ цогцсыг хөрч амжаагүй шахам байхад иймэрхүү юм ярихад хэн ч дургүйцнэ биз дээ...”;

3. “Сүхээ ах “Ахыгаа уучлаарай, би чамайг байрны бичиг баримтыг өөрийнхөө нэр дээр болгочихсон юм байх гэж бодлоо” гэж байсан. Маргаашаас нь Сүхбаатарын дүү Чинбаатар манай руу утасдаад намайг элдвээр загнахад нь “аргаа бараад би Чинбаатарт өвөөгийнхөө гэрээслэл бичгийг үзүүлээд...”;

4. “...Чинбаатар надаас уучлалт гуйгаад “Ах нь чамайг буруу ойлгож задлан хийдэг эмчтэй тохиролцон шинжилгэний дүнг “НО”-той гаргуулж чамайг шоронд хийлгэх шахлаа шүү дээ. Ахдаа юм бодохгүй юм байгаа биз дээ” гэж ярьж хөөрч суугаад гарахдаа намайг үнсчихээд явсан.”;

5. “Сүхээ ах, Чинбаатар хоёр энэ ганц өрөө байрыг авч 50, 50 хувиар нь мөнгийг нь хувааж авахаар тохиролцсон нь илт мэдэгдэж байгаа. Өвөөгийн 49 хоног өнгөрүүт тэр хоёр нийлж намайг байж суухын аргагүй болтол дарамталж байсан...энэ хооронд тэр хоёр тэр айлынхныг ч дарамталж байсан гэсэн.”;

6. “Арай ч дээ, Сүхээ ахаа. Ээжийг чинь би өргөж байгаад л бие баруулсан. Эцгийг чинь мөн адил би л толгойг нь түшсэн” гэхэд “Нээрээ тийм шүү” гэж хүлээн зөвшөөрч байсан...”;

7. “Бүгд л өөрсдийнхөө амьдралыг хөөж ээж, аавтайгаа ирж уулздаггүй шахам явж байснаа эзэнгүй байр гараад ирэнгүүт ингэтлээ улангасаж зүтгээд нутаглуулаад бараг жил болж буй эцгийнхээ шарилыг хөндөж, байрыг нь өөрийн болгох зорилгодоо ашиглах гэж байгаа нь дэндүү хэрцгий явдал. Ингэж ашиглах зорилготой, төлөвлөгөөтэй байснаа өвөөг өнгөрсний маргааш хэлэхэд миний дэргэд гэр бүл болох гэж байгаа хүн маань мөн аавын төрсөн дүү эмэгтэйн хүү эхнэртэйгээ хамт байцгаасан, бүгд сонссон...” гэх зэргээр бодит баримтыг бүрэн гүйцэт бус, хувийн нууцад хамаарах мэдээллийг зөвшөөрөлгүй, нэр төр, алдар хүндийг гутаасан ярилцлагыг “Сэрүүлэг” сонин нийтлэн гаргасан нь эргэлзээтэй юм.

2.2. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн баталгаа

Сэтгүүлчид бол нийгэмд хэрэгцээт мэдээллийг эрэн сурвалжлан, олон нийтэд дамжуулах /түгээх/ үүргийг олон нийтийн өмнө хүлээсэн мэргэжлийн ажилтан юм. Гэвч сүүлийн жилүүдэд сэтгүүлчийн мэргэжлийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн хэд хэдэн үйл явдал болсон юм. Тухайлбал, “Ардчилал” сонин, “Mongolia Online”-ийн “Орчлон” интернэт сонины сурвалжлагч, сэтгүүлч Л.Цэрэн-Очир, Америкийн дуу хоолой радио, мэдээллийн Инфо-105.5 радио, парламентын сэтгүүлч, сурвалжлагч Г.Уянга нар нь 2002 оны 11 дүгээр сарын 12-13 нд шилжих шөнийн 03 цагийн үед Сүхбаатарын талбайд байрлаж байсан “Газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөн”-өөс зохион байгуулсан жагсаалд оролцсон зарим иргэд болон тракторуудыг уг талбайгаас зайлуулах зорилгоор цагдаагийн байгууллагаас явуулсан ажиллагаа, болж буй үйл явцыг сурвалжлах, мэдээлэл цуглуулах зорилгоор уг газарт мэргэжлийн үйл ажиллагаа (дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, ярилцлага, сурвалжлага авах гэх мэт) явуулж байжээ.

Гэтэл цагдаа нар цуглаанд оролцогчдыг хүч хэрэглэн тараах, баривчлах үйл явцыг сурвалжлан ажиллаж байсан тэдгээр сэтгүүлчдийн дүрс бичлэг хийх үйлдлийг хориглон зогсоож, ажил үүргээ гүйцэтгэж байгаа сэтгүүлчийн мэргэжлийн үнэмлэх, бичиг баримтыг шалгаж үзэлгүй шууд бусадтай хоморголон баривчлан Дэнжийн мянгад байрлах цагдаагийн 5 дугаар тасгийн баривчлах байранд аваачиж 7 цаг саатуулан, зарим сэтгүүлчийн биед үзлэг хийж, дүрс бичлэгийн камер, бичлэг хийсэн хуурцагуудыг хураан авах замаар сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг зогсоосон явдал гарсан юм. Тухайлбал, цагдаагийн албан хаагчид:

1. Сэтгүүлч Г.Уянга бичлэг хийж байхад нь хориглон зогсоосон.

2. Сэтгүүлч Г.Уянга, Л.Цэрэн-Очир, Эрдэнэбат, Шинэбаатар, зураглаач Батбуян нарыг бичиг баримтыг нь шалган нягталж үзэлгүй бусадтай хоморголон баривчлан түр саатуулсан.

3. Сэтгүүлч Л.Цэрэн-Очирын биед үзлэг хийж электрон дүрс бичлэгийн болон гэрэл зургийн зориулалт бүхий камер 1 ш, зай, түлхүүр, мөнгө, сурвалжлагчийн үнэмлэх, бичлэгтэй диск, кассет зэргийг хурааж авсан зэрэг арга, хэлбэрээр сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулан, сэтгүүлчийн мэргэжлийн эрх, ашиг сонирхлыг хохироосон байна.

35

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол Улсын иргэн **“үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх...эрх чөлөөтэй”**, мөн зүйлийн 17 дахь хэсэгт **“...мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”** гэж заажээ.

Сэтгүүлчид болон тэдний өмгөөлөгчид Монгол Улсын эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд заасан **“Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх”** гэмт хэрэг үйлдэгдсэн гэж үзэн 2002 оны 12 дугаар сарын 3-ны өдөр УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албанд эрүүгийн хэрэг үүсгэж, шалгуулах тухай гомдол гаргасан боловч **“Сүхбаатарын талбайгаас жагсаал, цуглаан хийсэн иргэд, тракторуудыг уг талбайгаас гаргахдаа сэтгүүлчдийг хоморголон баривчилсан гэх үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй”** гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан байдаг. Иймд Нийслэлийн прокурорын газарт 2003 оны 2 дугаар сарын 17-ны өдөр гомдол гаргасан боловч **“албаны эрх мэдлээ хэтрүүлсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй”** гэсэн үндэслэлээр мөн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг эс зөвшөөрч 2003 оны 5 дугаар сарын 19-ны өдөр УЕПГ-т гомдол гаргасан ч **“цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглаанд оролцогчдыг албадан тараах үйл ажиллагааны явцад албан хаагчдаас эрүүгийн гэмт хэрэг үүсгэхээс татгалзсан материалыг сэргээх үндэслэлгүй гэж үзсэн”** болохыг УЕПГ-ын 2003 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн №511457 тоот хариу мэдэгдэх хуудсаар мэдэгджээ.

Хэдийгээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлээгүй боловч энэхүү үйлдэл нь цагдаагийн албан хаагчид хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ дагуу хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэхдээ хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байсан сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл гэдэг нь тодорхой болно.

Мөн өөр нэг тохиолдол бол **“Монголын Нэг Өдөр”** сонины сэтгүүлч А.Эрдэнэтуяад Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 235 тоот шийтгэх тогтоолоор түүнийг “Монголын нэг өдөр” сонинд сурвалжлагчаар ажиллаж байхдаа тус сонины 2003 оны 9-р сарын 35 дахь дугаартаа **“Д.Мөрөн гишүүний охин Камертоны Болдын ахын үхэлд буруутанаар тодрохдоо эцгийнхээ нэрийг тас нуужээ.”** гэсэн илт худал

нийтлэл бичиж хэвлэлээр тарааж бусдыг гүтгэсэн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдож байна гэж үзэж бусдыг гүтгэсэн гэмт хэрэгт гэм буруутайд тооцон Эрүүгийн хуулийн 111-р зүйлийн 111.2-т зааснаар А.Эрдэнэтуяаг 3 сар 01 хоногоор баривчлах ял оногдуулсан юм.

Судалгааны явцад хэргийн болсон нөхцөл байдал, шүүхийн шийдвэрийг шинжилэн үзэхэд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай зарим талаар нийцэхгүй, энэхүү хэргийн талаар шийдвэр гаргахад онцгой ач холбогдолтой хэд хэдэн нөхцөл байдал байсныг анхан шатны шүүх анхаарч, үнэлж үзээгүй байна. Тухайлбал,

1. Анхан шатны шүүх шийдвэртээ “А.Эрдэнэтуяа нь нийтлэлийг тус сонинд бичихдээ Өдрийн сониноос иш татан авч нийтлэл бичсэн гэсэн тэмдэглэл хийгээгүй...” байна. Өөрөөр хэлбэл “Өдрийн сонин”-г ашигласан гэдэг нь нотлогдохгүй байна гэж үзсэн. Сэтгүүлч А.Эрдэнэтуяа нь “Иш татсан гэсэн тэмдэглэл” хийгээгүй нь үнэн, гэхдээ “Өдрийн сонин”-г ашигласан гэдэг нь өөр 3 зүйлээр нотлогдож байжээ. Үүнд:

1.1. “Монголын Нэг Өдөр” сонинд гарсан нийтлэлийн агуулга нь “Өдрийн сонин”-д гарсан нийтлэлтэй үндсэндээ адил, дахин давтагдсан байсан;

1.2. “Өдрийн сонин”-ны нийтлэлийн дараа “МНӨ” сонины нийтлэл гарсан цаг хугацааны хувьд;

1.3. Сэтгүүлч А.Эрдэнэтуяа нь өөрийн мэдүүлэгтээ “Өдрийн сонин”-д Ууганцэцэгтэй хамт хоригдож байсан охинтой ярилцлага хийсэн байсан. Энэ ярилцлагад Мөрөн гишүүн тухайн үед няцаалт өгөөгүй, энэ талаар өөртэй нь холбогдох гэсэн утас нь дуудаад авахгүй байсан, “Өдрийн сонин”-д гарсан зүйлийг үндэслэн бичсэн гэж мэдүүлэг өгсөн нь “Өдрийн сонин”-г ашигласан болохыг нотлож байдаг. Гэтэл ийм тодорхой зүйлийг анхан шатны шүүх нотлогдохгүй байна гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байгаа юм.

2. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Гүтгэх” буюу 111-р зүйлийг жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн байна.

2.1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 111-р зүйлд заасан “Гүтгэх” гэмт хэрэгт хууль тогтоогч субъектив талын заавал байх шинжийг заасан байдаг.

Эрүүгийн хуульд зааснаар илт худал мэдээ сэлт тараасан этгээдэд "хүний нэр төр, алдар хүндийг гутаах" ямар зорилго байгааг заавал тогтоох ёстой. Гутаах зорилго нь тогтоогдвол үүнийг гэмт хэрэг үзнэ. Гэтэл шүүгдэгч А.Эрдэнэтуяад УИХ-ын гишүүн Д.Мөрөнгийн нэр төр, алдар хүндийг гутаах ямар зорилго, сэдэл байсныг анхан шатны шүүх шийтгэх тогтоолдоо дурдаагүй өөрөөр хэлбэл зорилгыг нь тогтоож чадаагүй байж гүтгэх гэмт хэрэг үйлдсэн гэж ял оногдуулсан. Үүнийг хуулийг зөрүүтэй ойлгож буруу хэрэглэсэн явдал гэж дүгнэхэд хүрч байна.

2.2."Гүтгэх" гэмт хэрэг нь гэм буруугийн хэлбэрийн хувьд шууд санаатай байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл,


1.Уг мэдээлэл нь илт худал гэдгийг гүтгэлэг тараагч этгээд ямарч эргэлзээгүй сайн мэдэж байдаг;

2.Уг мэдээлэл нь илт худал гэдгийг мэдсээр байж хүний нэр төр, алдар хүндийг гутаахын тулд тухайн гүтгэлгийг тараахыг хүсэж, түүнийгээ ухамсарлаж идэвхтэй үйлдлээр тараадаг.

Анхан шатны шүүх шүүгдэгч А.Эрдэнэтуяаг "уг нийтлэлийнхээ эх сурвалжийг тодорхой биш гэдгийг мэдсээр байж нийтэлсэн." үзсэн. Сэтгүүлч А.Эрдэнэтуяа тухайн үед энэ гүтгэлэг бүхий мэдээллийг илт худал гүжирдлэг гэдгийг мэдээгүй байсан. Хэн сайн мэдэж байсан бэ гэвэл гүтгэлгийг анх зохиож тараасан Баяртуяа, Чимгээ гэх этгээд л сайн мэдэж байсан. Сэтгүүлч А.Эрдэнэтуяа тэдний хамсаатан байсан бол харин сайн мэдэж байсан гэж хэлж болно. Гэвч тэдэнтэй ямар нэг холбоо сүлбээ байхгүй. Иймд тэр мэдээлэл илт худал гэдгийг тухайн үед мэдээгүй байсан, харин мэдэх боломжтой байжээ. Гэтэл шүүх гүтгэлгийг санаатай зохиож тараасан этгээд болон гүтгэлэгт итгэж үнэмшээд тараасан хоёрыг ялгаж салгаж үзээгүй. Энэ 2 нь зорилгоороо ялгаатай байжээ.

Сэтгүүлч А.Эрдэнэтуяа нь тухайн үед энэ худал мэдээлэлд бусдын адил итгэж үнэмших хэд хэдэн бодитой хүчин зүйл байсан. Үүнийг анхаарч үзээгүй. Үүнд:

1."Өдрийн сонин"-ы 2003 оны 9 сарын 17-ны дугаарт Х.Чимгээгийн "Д.Мөрөнгийн охины хэргийн талаар шүүхэд мэдүүлэг өгөхөд бэлэн байна." гэсэн гарчиг бүхий ярилцлага гарсан байсан;



2.Мөн тус сонины 26-ны өдрийн дугаарт “УИХ-ын гишүүн Д.Мөрөн охиныхоо ялыг хөнгөрүүлэхэд нөлөөлсөн үү?” гэсэн гарчиг бүхий нийтлэл гарсан байсан;

3.“Монголчуудын Амьдрал” сонины 2003 оны №14-т Р.Баяртуяа “Талийгаачийн үхэлд Мөрөн хурандаагийн охин буруутай” гэсэн гарчиг бүхий ярилцлага өгсөн байсан;

4.Хохирогчийн зүгээс тухайн үед энэ алдаатай, ташаа мэдээллийн талаар ямар нэг хариу тайлбар, няцаалт өгөөгүй байсан зэрэг юм.

“Гүтгэх” гэмт хэргийн гол онцлог бол тухайн гүтгэлэг тараагч этгээд уг мэдээллийг илт худал гэдгийг бүр сайн мэдэж байж тараадаг. Харин тухайн үед уг мэдээллийг үнэн гэж итгэж үнэмшиж байсан боловч тэр нь бодит байдал дээр худал байсныг гүтгэлэг гэж үздэггүй бөгөөд ийм тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх ёстой. Учир нь энэ бол хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой шууд санаатай үйлдэл биш юм.

Сэтгүүлч А.Эрдэнэтуяагийн мэдээллийн эх сурвалжаа шалгаж нягтлаагүй, хэвлэл мэдээллээр цацагдсан худал ташаа мэдээлэлд итгэн “үнэн” гэсэн итгэх сэтгэл автсан, мэдээлэл худал ташаа байж болохыг мэдэх боломжтой байсан боловч явуулж буй үйл ажиллагаандаа хайхрамжгүй хандан гаргасан мэргэжлийн алдааг хууль зүйн хувьд хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой шууд санаатай үйлдэл гэж үзэж болохгүй юм.

Энэ нь гэм буруугийн хэлбэрийн хувьд болгоомжгүй, хайхрамжгүй хандсан үйлдэл юм. Гэтэл үүнийг гэм буруугийн хэлбэрийн хувьд шууд санаатай гэж үзсэн нь буруу юм.

Шүүхийн дүгнэлтэд онцгой ач холбогдолтой бүхий 2 нотлох баримт харилцан зөрүүтэй байхад 1-ыг авч нөгөөг нь үгүйсгэсэн тухай үндэслэлээ заагаагүй байна. Тухайлбал, Сэтгүүлч А.Эрдэнэтуяа нь МНӨ сонинд сэтгүүлчээр ажиллаж байхдаа 2003 оны 35 дугаарт “Д.Мөрөн гишүүний охин “Камертон”-ы Болдын ахын үхэлд буруутнаар тодрохдоо эцгийнхээ нэрийг тас нуужээ.” гэсэн нийтлэлийг Ш.Цэнджав гэсэн зохиомол нэрээр, мөн оны 36 дугаарт “УИХ-ын гишүүн Д.Мөрөн “аавыгаа” зовоосныхоо төлөө уучлал гуймаар байна.” гэсэн нэр бүхий УИХ-ын гишүүн Д.Мөрөнгийн төрсөн охин гэгдээд байгаа Ц.Ууганцэцэгтэй хийсэн ярилцлагыг П.Ундараа гэсэн нэрийн дор тус тус нийтлэн гаргасан байдаг.

Эхнийх нь гүтгэлэг бүхий нийтлэл, хоёр дахь нь УИХ-ын гишүүн Д.Мөрөнгийн төрсөн охин гэгдээд байсан Ц.Ууганцэцэгтэй эмэгтэйчүүдийн хорих газар очиж хийсэн ярилцлага байсан. Энэ ярилцлагаар "Ц.Ууганцэцэг нь би УИХ-ын гишүүн Д.Мөрөнгийн охин биш, тэр хүнийг би таних ч үгүй, би өөрийн төрсөн эцэгтэй хүн, аав маань 2 жилийн өмнө нас барсан" гэсэн агуулга бүхий ярилцлага өгсөн. Энэ ярилцлагаар олон нийт тэр мэдээлэл илт худал байж гэдгийг мэдсэн, энэ үед ямар нэг хэрэг маргаан, зарга үүсээгүй байсан. Энэ ярилцлагыг сэтгүүлч А.Эрдэнэтуяа хийсэн нь анхнаасаа хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго агуулаагүй байсан гэдгийг нотлож байсан. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байсан бол өөрийгөө зөвтгөх зүйл хийж явах байсан. Гэтэл энэ 2 дахь ярилцлагыг үгүйсгэсэн үндэслэлээ заагаагүй. Энэ нотлох баримтыг үнэлэн үзээгүй байна.




ГУРАВ.ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ОЛЖ АВАХ, ТҮГЭЭХ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1.Гадаадын зарим улс орны мэдээлэл олж эрхтэй холбоотой хууль тогтоомжийн талаархи харьцуулсан судалгаа

Иргэний нийгэм хөгжиж, бэхжихийн хэрээр эрх зүйт ардчилсан төрийн үед хүлээн зөвшөөрөх болсон нийгмийн хяналтын нэг гол институт болохын хувьд болох мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг хангах асуудалд ардчилал өндөр хөгжсөн улс орон бүр ихээхэн ач холбогдол өгч түүнийг хангах арга зам, механизмыг байнга эрэлхийлэх болжээ.

Барууны улс орнуудад техник технологийн хөгжил дэвшлийн үр дүнд мэдээлэл нь нийгмийн бүхий л харилцаанд бодитой "нөлөөлөх хүчин зүйл" болж, мэдээллийн харилцааг зохицуулах, хуульчлах шаардлага зүй ёсоор тулгарч 1970-1980 онуудад Баруун Европын ихэнх улс орнууд мэдээллийн харилцааг зохицуулсан шинэ шинэ хууль тогтоомжуудыг батлан гаргасан байна. Тухайлбал, "АНУ нь 1967 онд "Мэдээллийн эрх чөлөөний хууль", 1974 онд "Хувийн мэдээллийг хамгаалах хууль", 1978 онд "Мэдээллэгчийн эрх зүйн статусын тухай хууль", 1982 онд "Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль", 1990 онд "Мэдээллийн эрин үеийн эрхийн тухай билль" зэрэг олон чухал хуулиуд гарчээ. АНУ нь 1978 онд эрүүгийн хуулиндаа "Компьютерийн гэмт хэрэг" гэсэн шинэ бүлэг нэмж оруулсан, ХБНГУ-д мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн аюулгүй байдлыг зохицуулахад чиглэгдсэн бүхэл бүтэн багц хуулиудыг (1981-1992) гарган, тэдгээрийг хэрэгжүүлэх журмуудыг бусад бүхий л хуулиудтай уялдуулан шинэчлэж, амьдралд хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгчээ. Их Британид 1983 онд "Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл болон мэдээлэлжүүлэлтийн боломжийн тухай хууль"-ийг батлан гаргасан ба түүнээс хойш төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн хоорондох харилцаанд мэдээллийн сүлжээ сувгаар харилцах явдал ихээхэн өргөжиж, эдүүгээ бодит зүйл болж чадсан аж. ОХУ-д 1993 оноос эхлэн мэдээллийн харилцааг зохицуулсан хуулиуд шинээр гарч эхэлсэн байна. 1993 онд "Засгийн газрын холбоо, харилцаа болон мэдээллийн тухай" хууль, 1995 онд "Мэдээлэл, мэдээлэлжүүлэлт, мэдээллийн



аюулгүй байдлын тухай хууль”, 1996 онд “Олон улсын мэдээллийн сүлжээ, солилцоонд оролцох тухай хууль” зэргийг гаргажээ.”¹¹


Сүүлийн үед дэлхийн ихэнх улс орнуудад мэдээллийн эрх чөлөөний гол цөм болсон мэдээлэл олж авах эрхийг хангах талаар бодитой алхам хийж, уг харилцааг тусгайлан зохицуулсан бие даасан хуультай болжээ. Тухайлбал, Швед, АНУ, Умард Ирландын Нэгдсэн Вант улс, Энэтхэг, Япон, Англи мөн Болгар, Унгар, Латви, Чех, Албани, Гүрж зэрэг манай улстай адил ардчилалын шилжилтийн үедээ байгаа улс орнуудыг дурдаж болно.

Судалгааны хүрээнд Франц, Бельги, Швед зэрэг 3 улсад мэдээлэл олж авах эрхийн харилцааг зохицуулсан бие даасан хуулиар мэдээлэл олж авах дэг болон мэдээлэл өгөхөөс татгалзах үндэслэл, давж заалдах журам, уг эрхээ эдлэхэд нь туслах чиг үүрэг бүхий үндэсний байгууллагын талаар тус бүрт нь хэрхэн зохицуулсан талаар судлан үзэв.

Франц улс

Франц улсад албаны мэдээлэл олж авах эрхийн харилцааг “Мэдээлэл болон эрх чөлөө”-ны тухай хуулиар зохицуулдаг байна. (1978) Уг хуулиар мэдээлэл олгохоос татгалзах буюу нууцлах мэдээллийн хүрээ нэлээд өргөн байгаа бөгөөд мэдээлэл олгохоос дараахь үндэслэлээр татгалзах талаар заажээ. Үүнд:

- 1.Засгийн газар, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны нууцлалтай холбоотой мэдээлэл;
- 2.Үндэсний батлан хамгаалах болон гадаад харилцаатай холбоотой мэдээлэл;
- 3.Улсын валют болон нийтийн зээлтэй холбоотой мэдээлэл;
- 4.Улсын аюулгүй байдал болон нийгмийн аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл;
- 5.Шүүх болон шүүхийн өмнөх үйл явцтай холбоотой мэдээлэл;
- 6.Хувийн хэргийн нууц;
- 7.Арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нууцлал;
- 8.Татварын болон гаалийн албан шалгалт үзлэгтэй холбоотой мэдээлэл гэх мэт;



¹¹ Д.Баярсайхан. Мэдээллийн эрх зүй: судлагдахуун, тогтолцоо., “Эрх зүй”, 8-9/2002

Мэдээлэл олж авах талаар ирүүлсэн санал, гомдлыг шалгах үүрэгтэй өндөр эрх мэдэл бүхий шүүхийн болон улс төрийн албан тушаалтнуудаас бүрдсэн "Захиргааны мэдээлэлд нэвтрэх тухай Комисс"-ыг уг хуулиар байгуулдаг байна. Төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд өргөдөл гаргагч эхлээд уг комисстой зөвлөлдөх бөгөөд уг байгууллага мэдээлэл эрж буй хүмүүст зааварчилгаа өгөх бөгөөд харин мэдээлэл олгохыг шаардах эрхгүй тул тухайн байгууллагыг мэдээлэл өгөхийг ятгаж хүсэлт тавьдаг байна.

Хэрвээ тухайн байгууллага мэдээлэл өгөхөөс дахин татгалзвал өргөдөл гаргагч захиргааны шүүхэд ханддаг. Тухайн татгалзсан байгууллага татгалзах шалтгаанаа өгөх үйл явц 2 сар хүртэл үргэлжилнэ. Захиргааны шүүх өргөдлийг барагдуулж асуудлыг шийдвэрлэтэл 6 сар шаардагддаг байна.

Бельги улс

Бельги улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд **"Хууль, дүрэм, журмаар ямар нэгэн болзол тавиагүй тохиолдолд хүн бүр засаг захиргааны бүх бичиг баримтыг ашиглаж, хуулбарлаж болно."** гэж заасан байна.

Үндсэн хуулиар баталгаажуулсан энэхүү мэдээлэл олж авах эрхийг "Засаг захиргааны нээлттэй байдлын тухай хууль"-иар нарийвчлан зохицуулжээ. Уг хуулиар тухайн улсын иргэн, цагаач хэн бүхэнд тэдний сонирхлоос үл хамааран эрх тэгш мэдээлэл авах эрхтэй, удирдлагын тогтолцооны талаар үнэгүй болон төлбөртэй мэдээлэл, зөвлөгөө өгөх үүргийг засгийн газрын болон орон нутгийн байгууллагын удирдлагад даалгасан байна.

Мэдээлэл авах хүсэлт тавигч тухайн байгууллагаас хүсэж байгаа мэдээллээ тодорхой бичиж нэр, хаягаа бичих ёстой. Хүсэлт нь ойлгомжгүй, хэтэрхий ерөнхий байвал хүлээж авахаас татгалзах эрхтэй. Тухайн байгууллага мэдээлэл авах хүсэлтэд 30 хоногийн дотор хариу өгөх ёстой бөгөөд шаардлагатай бол 15 хоногоор сунгадаг. Дараахь үндэслэлээр мэдээлэл өгөхөөс татгалздаг. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах;
2. Бусдын эрхийг хамгаалах үүднээс;
3. Олон улсын харилцаа, нийтийн энх тайван байдал;
4. Гэмт хэргийн мөрдлөгийн мэдээлэл;
5. Холбооны эдийн засаг, санхүү;

6.Бүрэн бус бичиг баримтыг олон нийтэд зарлавал буруу ташаа ойлголт өгөх зэрэг нөхцөлд тус тус татгалзахаар заажээ.

Харин мэдээлэл олж авсан иргэн мэдээллээ худалдахыг хориглодог байна.


Уг хуулиар мэдээлэл олж авах хүсэлт гаргагчид дэмжлэг, туслалцаа, зөвлөгөө өгөх зорилго бүхий “Засаг захиргааны бичиг баримттай танилцах комисс”-ыг байгуулдаг байна. Төрийн байгууллагаас мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгсөн тохиолдолд уг комисст хандах бөгөөд комисс тухайн байгууллагад тушаах эрхгүй учир зөвхөн мэдээлэл өгөх тухай санал тавьдаг. Хуулиар нийт 105 хоног хүртлэх хугацаанд хүсэлтийг хүлээж аваагүй бол шүүхэд ханддаг байна.

Швед улс

Хэвлэлийн эрх чөлөөг дээдэлж, албан баримт материалуудтай танилцах эрх нь хангагдсан байдаг учраас Швед улсыг дэлхий дээрхи хамгийн нээлттэй орон гэж хэлж болох юм.

Нээлттэй байх зарчим бол Шведийн Үндсэн хуулийн үзэл санаа байдаг. Засгийн газрын тухай хууль /1974/, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль /1949/, Үг хэлэх эрх чөлөөний тухай хууль гэсэн 3 хууль нь Шведийн үндсэн хуулийн бүрдэл хэсэг болдог байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө өөрөөр хэлбэл мэдээлэл дамжуулах эрх чөлөө, үзэл бодол, бодол санаа, сэтгэлийн хөөрлөө амаар бичгээр үйл хөдөлгөөнөөр болон бусад арга хэлбэрээр илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө өөрөөр хэлбэл мэдээлэл олж авах, хүлээж авах, бусдын хэлсэн ярьсан зүйлтэй танилцах эрх чөлөөг засгийн газрын тухай хуулиар бүх иргэдэд баталгаажуулсан байна.

Засгийн газрын тухай хуулиар олгогдсон эрхийг зөвхөн аливаа ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хязгаарлаж болно. Үзэл бодлоо илэрхийлэх мэдээлэл авах эрхүүдийг зөвхөн үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нийгмийн амгалан тайван байдлыг хангах, гэмт хэрэг, хэлмэгдүүлэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор хязгаарлаж болно. Эдгээр эрхтэй холбоотой хэргүүдэд хамгийн өргөн боломж олгож буй эрх чөлөөний ач холбогдлыг харгалзан үзэх ёстой байдаг. Засгийн газрын тухай хуулийн үг хэллэг ихэвчлэн ерөнхий байдаг бол хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан тодорхой заалттай байдаг.



Энэ хуулиар аливаа бичмэл материалыг хэвлүүлэх, үүнийхээ төлөө мөрдөгдөн мөшгөгдөхгүй байх эрхийг баталгаажуулах бөгөөд нийтэд хүргэх мэдээллийг хязгаарлахгүйгээр нийтийн дэг журмыг сахихаар тогтоосон хуулийн дагуух тохиолдлоос бусад тохиолдолд дээрх эрхийг аливаа төрийн байгууллагын зүгээс тавих хориг саадгүйгээр эдэлнэ. Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн 2-р бүлэгт нээлттэй зарчмын талаарх үндсэн хуулийн заалтуудыг илүү тодорхой заажээ. Тухайлбал, санал бодлоо чөлөөтэй солилцох олон түмнийг гэгээрүүлэх явдлыг дэмжих зорилгоор Швед дэх субъект бүр албан хэргийн баримт материалтай чөлөөтэй танилцаж болно гэжээ.

Дараах зүйлстэй холбоотой мэдээлэлтэй танилцахыг хориглодог байна. Үүнд:

1. Шведийн вант улсын буюу түүний гадаад улс болон олон улсын байгууллагатай харилцах харилцааны аюулгүй байдал;
2. Санхүүгийн төвлөрсөн бодлого, мөнгөний бодлого буюу вант улсын гадаад валютын арилжааны бодлого;
3. Төрийн байгууллагын хяналт шалгалт буюу бусад хяналтын үйл ажиллагаа;
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мөрдөн байцаалтын эрх ашиг;
5. Хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах буюу хувийн хэвшлийнхний санхүүгийн байдал ургамал, ан амьтдын төрөл ангийг хамгаалах зэрэг болно.

Эдгээр хязгаарлалтыг маш нарийн ангилсан байх ёстой ба парламент эсвэл засгийн газар эдгээр хязгаарлалтаас үл хамааран холбогдох мэдээллийг нийтэд ил болгохыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж болдог байна.

Шведийн үндсэн хуулчилсан хууль тогтоомжинд нууцлалын тухай мэдээлэл олж авах заалтуудыг нэлээд нарийн хэлбэрээр томъёолсон байдаг. Шведийн иргэн бүр Стокольм дахь ерөнхий сайдын байранд нэвтрэх, ерөнхий сайдад захидал илгээмж хүлээх эрхтэй байдаг. Онцгой шалтгаан байхгүй бол хүссэн мэдээллийг заасан хугацаанд өгөх ёстой байдаг.

Мэдээлэл авахыг хүсээд татгалзсан хариу авсан хэн болгон захиргааны шүүхийн байгууллага, цаашлаад захиргааны дээд шүүхэд зарга мэдүүлэх эрхтэй байдаг. Давж заалдах гурван хэлбэр байдаг бөгөөд зарим хэлбэрийг нь хуульд тусгаагүй байна. Эхний шатанд тухайн байгууллагад буюу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах, хоёр дахь шат нь тухайн асуудлыг хариуцсан хүний эрхийн байгууллагад хандах /Омбудсмен, Хүний эрхийн Комисс/ гурав

дахь шат нь шүүхэд хандах зэрэг болно. Хоёр дахь шат буюу хараат бус байгууллагад хандах асуудал нь мэдээллийн эрх чөлөөний хуулийн гол элемент юм. Иргэд шүүхэд давж заалдахтай холбогдсон зардал, цаг алдалтыг тойрох, хууль эрх зүйн ээдрээтэй маргаангүйгээр тухай байгууллагын шийдвэрийг хөндлөнгийн байгууллагаар хянуулах, өөрчлөх боломжыг бий болгодог.

Мэдээлэл олж авах эрхийг бусад улс.орныхтой харьцуулан үзвэл, манай орны хувьд уг эрхийг хангах эрх зүйн механизм бүрдээгүй байна.

1. Судалгаанд хамрагдсан Монгол Улсын төрийн захиргааны ихэнх байгууллага нь хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг бүхий газар, хэлтэс, албатай байна. Эдгээр нэгж нь иргэдэд мэдээлэл өгөх, ил тод нээлттэй байдлыг хангах чиг үүргээс илүүтэйгээр байгууллагын тайлан мэдээ, баримтыг удирдах байгууллага, албан тушаалтан болон төрийн эрх бүхий зарим байгууллагад ажил тайлагнах зорилгоор цөөн тоогоор хүргүүлэх, статистик тоо, баримтад дүн шинжилгээ хийж ажлын хэрэгцээнд тараах, байгууллага сурталчилах зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Цаашид иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх, ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр идэвхтэй ажиллах шаардлагатай байна. Судалгаанд оролцогч төрийн байгууллагууд олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материал (26 байгууллага), байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн тухай тогтмол мэдээлэл (22 байгууллага) түгээдэг гэж хариулсан ч бодит байдал дээр ийм мэдээлэл туйлын хомс байна.

Мөн төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь ач холбогдол багатай байгууллагын мэндчилгээ, зар сурталчилгаанд ихээхэн хэмжээний мөнгө зарж байгаа нь буруу юм.

2. Төрийн байгууллагууд нь өөрийн мэдэлд байгаа мэдээлэл, баримт бичгийг **“албаны баримт бичгийг энгийн иргэнд хамаагүй өгч болохгүй”** гэсэн хуучны үзэл сэтгэлгээ, арга барилаас салаагүй, мэдээлэл, баримт бичиг өгөхөд удирдлагаас зөвшөөрөл авах явдал байна. Энэ нь төрийн байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичгийг нууцлах хандлага бодитойгоор оршиж байгаа харуулж байгаа хэрэг юм.

3. Төрийн захиргааны зарим байгууллага нь Байгууллагын нууцын тухай хуульд зааснаар байгууллагын нууцын жагсаалт, түүнийг хамгаалах, хадгалах журмаа батлаагүй, мөн зарим нь нууцын жагсаалтаа байгууллагын нууцад хамааруулсан, нууцад хамааруулах шаардлагагүй баримт бичиг, мэдээллийг байгууллагын нууцад хамааруулж байгаа нь мэдээлэл чөлөөтэй хүртэх эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

4.Төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх амьдрал дээр хэр зэрэг хэрэгжиж байгаа талаар явуулсан судалгаагаар судалгаанд оролцогсдын:

- 4 хувь нь “хангалттай”;
- 28 хувь нь “дунд зэрэг”;
- 68 хувь нь "тааруу", "огт хэрэгжихгүй байгаа" гэж, мөн судалгаанд оролцогсдын 69 хувь нь төрийн ямар нэг байгууллагаас мэдээлэл олж авах хүсэлтийг гаргаж байгаагүй гэж хариулсан бөгөөд тэдгээр иргэд энэ шалтгаанаа:
 - төрийн байгууллага, албан тушаалтан мэдээлэл өгдөггүй;
 - танил тал байхгүй;
 - хүнд сурталтай гэж үздэгээс ханддаггүй гэжээ. **"Хүссэн мэдээллээ**

төрийн байгууллагаас авч чадсан уу? " гэсэн асуултад нийт судалгаанд оролцсон хүний 75 нь ямар нэг байдлаар хариулсан бөгөөд чадсан гэж тэдний дөнгөж 9 хүн нь, зарим үед гэж 5 хүн нь хариулсан бол үлдсэн 61 хүн нь авч чадаагүй гэжээ. Авч чадаагүй үндэслэлээ тэд тайлбарлахдаа удирдлага нь зөвшөөрөөгүй, мэдээлэл байхгүй, албан хэргийн бичиг баримтыг жирийн иргэнд өгөхгүй, мэдээллийг ашиглах зорилгоо хэлсэн чинь өгөөгүй гэх зэргээр хариулсан нь иргэдийн мэдээлэл хайх, олж авах эрх бодит байдал дээр хэрэгжихгүй байгааг харуулж байгаа болно. Монгол Улсын иргэнд төрийн /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага/ үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар харах бололцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

5.Иргэдийн төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрхийг хангах үндэсний механизмыг бүрдүүлэх нь Манай улс шиг ардчилалын хөгжил, соёл, төвшин бага, төрийн байгууллагад тогтсон хүнд суртал, мэдээллийг нууцлах зуршлыг арилгаж мэдээллийн эрх чөлөөг бодитойгоор төлөвшүүлэхэд нэн чухал ач холбогдолтой байна. Улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан бусад ардчилал, эдийн засаг хөгжсөн улс орнуудад байдаг “Мэдээллийн Үндэсний Байгууллага” байгуулах асуудал боломж бага юм. Харин Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын нэг чиг үүрэг нь хууль тогтоомж, захиргааны шийдвэрүүд хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал, зөвлөмж гаргах явдал байдаг. Иймд мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг хангах чиглэлээр Хүний Эрхийн Үндэсний Комиссын чиг үүрэгтэй уялдуулан зохицуулах боломжтой. Комисс нь төрийн байгууллага, албан хаагчидад сургалт явуулах ажлыг удирдан зохион байгуулж, мэдээлэл

өгөхөөс татгалзсан тухай өргөдөл, гомдлыг хянаж, тухайн байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөх, мэдээллийг нээлттэй ил тод байлгах чиглэлээр сайн ажиллаж байгаа төрийн байгууллагуудыг урамшуулах, нууцлаг асуудалд хандсан кампант ажил өрнүүлэх, үйл ажиллагаагаа сайжируулж байгаа байгууллагыг дэмжих, мэдээлэл, үйл ажиллагаагаа нууцалдаг байгууллага, албан тушаалтаныг шүүмжлэх зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулах юм.

Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комисс нь мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийн талаар олон нийтийн боловсролыг дээшүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах нь тодорхой юм.

Мөн төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа мэдээллийг хадгалах, хамгаалах талаар нэгдсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгтэй бөгөөд мэдээллийг санаатайгаар нуух, устгах үйлдлийг хориглон хууль зүйн хариуцлага хүлээлгэх нь уг эрхийг хангах гол механизм болно.

6.Сүүлийн жилүүдэд мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах хууль тогтоомж батлах, хэрэгжүүлэх талаар дэлхийн олон улс оронд нилээд дорвитой алхам хийж байна. Үүний үр дүнд нилээд улс орон мэдээлэлд нэвтрэх, мэдээлэл олж авах эрхийн харилцааг тусгайлсан зохицуулсан хуультай болсон. Тухайлбал, Япон, Энэтхэг, Англи, Швед, АНУ, Финлянд, Нидерланд, Австрали, Канад, мөн Унгар, Латви, Чех, Болгар, Албани, Гүрж зэрэг улс орнууд ийм хуультай болсон байх юм. Энэ хууль нь иргэний мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг хангахад чухал ач холбогдолтой байдаг. Манай улсад мэдээлэл олж авах эрхийг хангах бие даасан хуулийг батлан гаргах шаардлага байна.

7.Иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид үг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.2-т заасан “Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” гэсэн Монгол Улсын иргэний үндсэн үүргийг биелүүлэхгүй байна. Үүний улмаас сүүлийн жилүүдэд нэр төр, алдар хүндтэй холбоотой хэрэг, маргаанд сэтгүүлчид буруутах нь цөөнгүй болов. Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө жам ёсоор төлөвшин тогтох үйл явцад сөргөөр нөлөөлж байна. Нөгөө талаар НҮБ-аас гишүүн улс орнууддаа эрүүгийн хуульд заасан доромжлох, гүтгэх гэмт

хэргээ хасах саналыг дэвшүүлж байгааг дэмжих нь зүйтэй юм. Хүний нэр, нэр төр, алдар хүндтэй холбоотой хэрэг, маргааныг иргэний журмаар шийдвэрлэдэг байх нь тохиромжтой. Гэхдээ хувийн нууц, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн халдашгүй байдал, гэм хорын хохирлын асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай юм. Харин эрүүгийн хуулийн 231, 259 дүгээр зүйлд заасан шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан гүтгэх, доромжлохыг гэмт хэрэг тооцсон зүйлийг хэвээр үлдээх нь зөв юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагааг нээлттэй болгож, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн нөлөөлөх, оролцох арга замыг шинэ хэлбэрээр боловсронгуй болгох;

2. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн зохицуулалтын механизм бий болгох (Хэвлэлийн зөвлөл, омбудсмен, редакцийн хараат бус байдал)


3. Төрөөс хэвлэл мэдээллийн салбарт ардчилалыг бодитойгоор хэрэгжүүлэх, мэдээллийн олон талт эх сурвалжыг хамгаалах үүднээс хэвлэл мэдээллийн салбарт дангаар ноёрхох явдлыг хязгаарлах

4. Иргэдээс төрийн байгууллага, төрийн өндөр албан тушаалтан, улс төрчид, нийгмийн зүтгэлтэн хүмүүсийн талаар өөрийн үзэл бодол, шүүмжлэлээ чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн баталгаа (зарчим) бүрдүүлэх

5. Иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид мэдээллийн нууцыг олон нийт, нийгмийн эрх ашгийн үүднээс задаруулах, уг мэдээлэл олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээлэл болохыг шүүхээс тогтоосон тохиолдолд хариуцлага хүлээлгэхгүй байх

6. Иргэдээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр төр халдашгүй байх эрхийг хөндөхгүй байх, уг эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, няцаалт хийх эрхийг бүрэн сэргээх эрх зүйн механизмийг боловсронгуй болгох

7. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдон байгууллагын нууцын тухай хуульд нууцад хамааруулахгүй байх мэдээллийн хүрээ, байгууллагын нууц тогтоох журмыг шинэчлэх зэрэг чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах



Хавсралт-1

**“Мэдээлэл”-тэй холбоотой асуудлыг хариуцдаг газар, хэлтэс,
алба, хэвлэлийн төлөөлөгчтэй төрийн
байгууллагуудын нэрс**

№	Байгууллагын нэр	Газар, хэлтэс, алба, төвийн нэр	Бүтэц, орон тоо
1.	Хууль зүй, дотоод хэргийн яам	Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар (хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба)	Тухайн асуудлыг хариуцсан 2 мэргэжилтэн бий.
2.	Үйлдвэр худалдааны яам	Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар (орон тооны бус мэдээллийн нээлттэй төв)	
3.	Санхүү, эдийн засгийн яам	Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар /мэдээлэл, хяналт, шинжилгээний 2 албатай/	7 хүний орон тоотой
4.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар	6 хүний хүнтэй, ТЗУГазарт мэдээлэл хариуцсан 1 хүнтэй.
5.	Батлан хамгаалах яам	Хэвлэл, олон нийттэй харилцах хэлтэс	Дарга, сурталчилгаа хариуцсан, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн бүгд 3 хүний орон тоотой.
6.	Нийслэлийн засаг даргын тамгын газар	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба	
7.	Улсын иргэний хамгаалалтын газар	Сургалт, сурталчилгааны хэлтэс	1 ажилтан
8.	Зэвсэгт хүчний жанжин штаб	МСХХэлтэс	Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн, ЗХЖШтабын хэвлэлийн төлөөлөгч 1 хүн, ЗХЖШтабт орон тооны бус хэвлэл мэдээллийн алба 9 хүний бүрэлдэхүүнтэй
9.	Хил хамгаалах ерөнхий газар	Сургалт, хүмүүжлийн газар, ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын хэлтэс	
10.	БХБНААГазар	Мэдээлэл үйлчилгээний хэлтэс	7 хүний орон тоотой
11.	Улсын мэргэжлийн хяналтын газар	Мэдээлэл, хяналт, шинжилгээ судалгааны хэлтэс	Хэвлэлийн төлөөлөгч ороод 6 хүн ажилладаг

12.	Гадаад харилцааны яам	Хэвлэл мэдээллийн хэлтэс	5 хүн ажилладаг
13.	Эрүүл мэндийн яам	Хэвлэл, олон нийттэй харилцах хэлтэс	Дарга, олон нийтийн санал асуулга, судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн
14.	Монголбанк	Хэвлэл мэдээллийн алба, судалгааны хэлтэс	
15.	Улсын нөөцийн газар	Тамгын хэлтэс	Мэдээлэл хариуцсан нэг мэргэжилтэн
16.	Дэд бүтцийн яам	Хэвлэл мэдээллийн алба, гэж ажилладаг, 2003 оноос мэдээлэл, холбооны технологийн газар шинээр ажиллана.	
17.	Үндэсний статистикийн газар	Мэдээлэл тархаалтын баг	Мэдээлэл тархаалтын баг нь 5 хүнтэй /эх бэлтгэгч, хэвлэлгч ороод/
18.	ҮТЕГазар	Сургалт, мэдээллийн хэлтэс	6 хүний орон тоотой.
19.	ТЕГазар	Хэвлэл мэдээллийн алба	
20.	СБД-ийн ЗДТГазар	ТЗУХэлтэс	Хэвлэл мэдээлэл хариуцсан нэг ажилтан
21.	ЧД-ийн ЗДТГазар	Дүүргийн лавлах, мэдээлэл сурталчилгааны төв	1 хүн ажилладаг
22.	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	/мэдээллийн төв /, захиргааны хэлтэс	Нэг мэргэжилтэн
23.	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг	Мэдээлэл төлөвлөлтийн баг	2 хүн ажилладаг
24.	Түлш, эрчим хүчний ерөнхий газар	Хэвлэл мэдээллийн орон тооны бус хэсэг	11 хүний бүрэлдэхүүнтэй, үүний 7 нь ТЭХЕГ-ын хүмүүс, 4 нь хэвлэл мэдээллийн байгууллагын хүмүүс байдаг, ТЭХЕГазарт хэвлэл мэдээллийн нэг ажилтан
25.	Үндэсний архив	Эрдэм шинжилгээ, мэдээлэл, лавлагааны тасаг	Одоо бүтцийн өөрчлөлт явагдаж байна.
26.	ХУД-ийн ЗДТГазар	Гадаад харилцаа, хэвлэл мэдээллийн алба	Дарга, гадаад харилцаа хариуцсан нэг мэргэжилтэн, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан нэг мэргэжилтэн бүгд 3 хүнийн бүрэлдэхүүнтэй

27.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтан	
28.	Гаалийн ерөнхий газар	Хэвлэл мэдээлэл хариуцсан нэг хэвлэлийн төлөөлөгч	
29.	Улсын нийгмийн халамжийн газар	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны асуудал эрхэлсэн мэргэжилтэн	
30.	УЕПГазар	Хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн нэг орон тоотой	
31.	Авто замын газар	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, техник, технологи, статистикийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, архивын мэргэжилтэн	
32.	Газрын тосны газар	Хавсарч ажилладаг мэргэжилтэн	
33.	Гал түймэртэй тэмцэх газар	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ахлах байцаагч	
34.	Оюуны өмчийн газар:	Хариуцсан албан тушаалтан	
35.	ГХГЗЗГазар	Хэвлэл мэдээлэл хариуцсан 1 ажилтантай	

ХАВСРАЛТ

- 1."ОНМХ-Нийгмийн сэтгэл зүй" сэдэвт судалгааны тайлан
- 2."Нууцлал ба мэдээллийн эрх чөлөө" дугуй ширээний уулзалтын материал
- 3.Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал, ажлын албаны нууцын дотоод журам
4. Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газрын нууцын тухай журам, нууцын жагсаалт
- 5.Сэтгүүлчдэд холбогдох иргэн, байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан эрүү, иргэний хэргүүдийг 2002 оны байдлаар судалсан тойм
- 6."Глоб интернэйшнл" ТББ, Мэдээллийн эрх чөлөө дугуй ширээний ярилцлага-тэмдэглэл, 2002 он
- 7."Глоб интернэйшнл" ТББ, "Олон нийтийн мэдэх эрх ба мэдээллийн эрх чөлөө", УБ., 2002 он
- 8.Хэвлэлийн Хүрээлэн, "Монголын хэвлэл мэдээллийн мониторинг 2003 он", УБ., 2004 он